



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Дэд  
Дугардорж ОЮУНБИЛЭГ

**ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ  
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ПРОЦЕССЫН  
АСУУДЛУУД**



Мэргэжлийн индекс  
042101

Эрх Зүйн бакалаврын зэрэг  
Горилсон дипломын төсөл

Удирдсан  
С.Батхүлэг/Ph.D/

Улаанбаатар. 2025



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ**

Дэд  
Дугардорж ОЮУНБИЛЭГ

**ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ  
ХУГАЦААНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН  
ПРОЦЕССЫН АСУУДЛУУД**



Мэргэжлийн индекс  
042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг  
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: ..... С.Батхүлэг / Ph.D /

Шүүмжлэгч: .....

Улаанбаатар. 2025

## **ГАРЧГИЙН ТОВЬЁГ**

МЭДЭГДЭЛ .....	i
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	ii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iii
ТАЛАРХАЛ.....	iv
ТОВЧ ХУРААНГУЙ.....	v
ОРШИЛ .....	1
Судалгааны ажлын зорилго .....	<b>1</b>
Судалгааны ажлын зорилт.....	<b>1</b>
Судалгааны арга зүй.....	<b>2</b>
I БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ .....	4
1.1 Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны онол түүхэн уламжлал эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт.....	<b>4</b>
1.2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн агуулга ба 2020 оны нэмэлт, өөрчлөлтийн утга, зорилго .....	<b>10</b>
II. БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ .....	24
2.1 Хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн процессын эрх зүйн үүднээс авч үзэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь зохицуулалт .....	<b>24</b>
2.2 Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжинд хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгасан байдал.....	<b>31</b>
САНАЛ .....	48
ДҮГНЭЛТ.....	50
НОМ ЗҮЙ .....	52

## МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төсөл нь миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: Д.Оюунбилэг

Гарын үсэг:

Огноо:2025.06.10

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт. 1.1. 2002, 2015 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны гол ялгаа.2002, 2015 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны гол ялгаа.....	10
Хүснэгт 1.2 Үндсэн хуулийн цэц гомдол.....	17
Хүснэгт 2.1 Эрүүгийн хэргийн бүртгэл 2024 Улсын хэмжээнд.....	24
Хүснэгт 2.2 Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүн.....	27
Хүснэгт 2.3 Франц улсын хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа .....	39
Хүснэгт 2.4 Франц улсын хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа .....	40
Хүснэгт 2.5 Богино хугацаа (бууруулаагүй тусгай хугацаа):.....	40
Хүснэгт 2.6 Франц Монголын харьцуулалт.....	46

**ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 2.1 Эрүүгийн хэргийн бүтгэл, шийдвэрлэлт.....	25
Зураг 2.1 Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн 2024, 2025.....	27
Зураг 2.3 Баянзүрх дүүрэгийн хэргэсгүй болсон хэрэг.....	30

## ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын дипломын төсөл бичихэд туслалцаа үзүүлэн, удирдан зөвлөж, алдаа бүхнийг засаж зөв болгож өгсөн удирдагч С.Батхүлэг багш болон шүүмжлэгч багш мөн тэнхимийн бүх багш нартаа талархал илэрхийлье

## ТОВЧ ХУРААНГУЙ

Эрүүгийн эрх зүйн гол зорилго нь хүний эрх эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх замаар нийгэмд шударга ёсыг тогтоох явдал юм. Гэвч Монгол улсын эрүүгийн хуульд зарим зохицуулалт, тухайлбал гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар эрх зүйн тодорхой бус байдал, онол практикийн зөрчил байсаар байна. Хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн эрх зүйн тогтолцооны чухал бүрэлдэхүүн боловч түүнийг тоолох зарчим хэрэглэх нөхцөл нь хуульд бүрэн тодорхойгүй байгаа нь шүүхийн практикт хүндрэл учруулж, гэмт этгээд ял завших, хохирогч эрхээ эдлэх боломжгүй болох сөрөг үр дагавар дагуулж байна. Энэхүү судалгаа нь хөөн хэлэлцэх хугацааны онолын үндэслэл, Монголын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, практикт үүсэж буй хүндрэлүүдийг судалж, олон улсын эрх зүйн туршлага дээр үндэслэн зохицуулалтыг сайжруулах шийдлийг боловсруулах зорилготой юм

**Түлхүүр үг:** *Гэмт хэрэг, Хөөн хэлэлцэх хугацаа, Эрүүгийн эрх зүй, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц,*

## Сэдэв сонгосон үндэслэл

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа бол эрүүгийн эрх зүйн суурь зохицуулалтын нэг хэсэг бөгөөд хүний эрх, шударга ёс, хууль хэрэгжилтийн үр нөлөөтэй салшгүй холбоотой чухал асуудал юм. Монгол Улсад энэхүү зохицуулалт олон жилийн туршид үе шаттайгаар өөрчлөгдөж ирсэн боловч өнөөг хүртэл хууль хэрэглээний түвшинд тодорхойгүй байдал, онол-практикийн зөрчил үүсэж, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, шүүхийн практикт бодит хүндрэл, зөрчилдөөн бий болгоод байна.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн эрх зүйн суурь ойлголтын нэг бөгөөд хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хариуцлагын үр нөлөөг хязгаарлах, шударга ёсыг сахиулахад чухал ач холбогдолтой. Монгол Улсад энэ зохицуулалт олон жилийн туршид өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн хэдий ч өнөөдрийн байдлаар хууль хэрэглээний түвшинд онол, практикийн маргаан үүсгэж, тодорхойгүй байдал бий болоод байна.

Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааны материаллаг болон процессын шинжтэй холбоотой Үндсэн хуулийн Цэц, Улсын Дээд Шүүхийн тайлбарууд хоорондоо зөрүүтэй гарсан нь шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын түвшинд нэг мөр ойлголт, хэрэглээ тогтооход ноцтой хүндрэл үүсгэж байна. Үүний улмаас практик дээр гэмт хэрэгтнүүд ял завших, хохирогчид эрхээ хамгаалуулах боломжоо алдах эрсдэл бий болж, хууль хэрэгжилтийн үр нөлөө, эрх зүйн тогтвортой байдал, нийгмийн шударга ёс, хүний эрхийн хамгаалалд шууд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь зөвхөн хууль зүйн онолын маргаан бус, эрх зүйн бодит асуудал тул онол, практикийн үүднээс нарийвчилсан судалгаа, гүнзгий шинжилгээ шаардсан, нэн тулгамдсан сэдэв болж байна.

Нөгөө талаас, олон улсын эрх зүйн туршлагаас харахад Франц, Герман, Япон зэрэг улсуудад хөөн хэлэлцэх хугацааг тооцох, ямар гэмт хэрэгт үл хэрэглэгдэх, ямар нөхцөлд хугацаа зогсох талаар нарийн тогтсон журам, хэрэгжилттэй байдаг нь Монгол Улсын нөхцөлд харьцуулсан судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, практик хэрэглээг шинэчлэх шаардлага, боломж байгааг тод харуулж байна.

Иймд уг сэдэв нь онолын ач холбогдолтой байгаад зогсохгүй, хууль зүйн практик хэрэгцээ, бодит нөхцөл, нийгмийн шаардлагаас урган гарсан, зайлшгүй судлах шаардлагатай, ач холбогдол бүхий тулгамдсан асуудал юм.

## **ОРШИЛ**

### **Судалгааны ажлын зорилго**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд үйлчилж буй хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын онолын үндэслэл, хууль зүйн шинж чанар, түүхэн хөгжил болон хэрэглээний практикт үүсэж буй зөрчил, бэрхшээлийг судлан шинжлэхэд оршино. Тус хугацаа нь эрүүгийн эрх зүйн хариуцлагын үр нөлөө, хүний эрхийн баталгаа, төрийн яллах ажиллагааны зохистой хязгаарлалтад шууд нөлөөлдөг чухал институт бөгөөд уг зохицуулалт Монголын хууль тогтоомжид хэрхэн төлөвшсөн, хэрэглээний явцад ямар эргэлзээ, хийдэл, эрх зүйн зөрчил үүсгэж байгааг онол практикийн үүднээс тодорхойлох нь энэхүү судалгааны төв асуудал юм. Үүний хүрээнд, судалгааны зорилго нь нэгдүгээрт, хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинжийг материаллаг болон процессын хэм хэмжээний хүрээнд онолын хувьд задлан шинжлэх; хоёрдугаарт, 2015, 2017, 2020 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх гуравдугаарт, Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт болон Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбарын хооронд үүссэн зөрчлийн агуулга, эрх зүйн үр нөлөөг задлан шинжлэх дөрөвдүгээрт, мөрдөн шалгах ажиллагааны шатанд хөөн хэлэлцэх хугацаанаас шалтгаалан хэрэг хаагдах нөхцөлийн бодит статистик дүн, практик үр дагаварт дүн шинжилгээ хийх; тавдугаарт, Франц, Герман, Япон зэрэг улс орны эрх зүйн туршлагыг харьцуулан судалж, Монгол Улсын хууль тогтоомжид тохирох шинэчлэлийн бодит боломжийг тодорхойлох зорилготой юм. Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын өнөөгийн байдлыг эрх зүйн шинжлэх ухааны үүднээс дүгнэж, хууль зүйн тодорхой байдал, шүүхийн нэгдмэл хэрэглээ, хүний эрхийн баталгааг хангасан үр нөлөөтэй зохицуулалтыг боловсронгуй болгох онол-практикийн үндэслэл бүхий санал, шийдэл боловсруулах нь энэхүү судалгааны гол зорилго юм.

### **Судалгааны ажлын зорилт**

Энэхүү судалгааны хүрээнд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинж, агуулгыг онолын түвшинд задлан шинжилж, түүний материаллаг болон процессын шинжийг ялган тодорхойлох зорилт тавигдаж байна. Ингэснээр уг хугацаа нь эрүүгийн эрх зүйн аль хүрээнд хамаарах асуудал болохыг онолын үндэслэл, олон улсын эрх зүйн жишигт тулгуурлан дүгнэх шаардлагатай.

2. Монгол Улсад 1926 оноос хойш хэрэгжсэн эрүүгийн хуулиуд дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын түүхэн хөгжил, шинэчлэл, үр нөлөөг судална.
3. 2015, 2017, 2020 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөөн хэлэлцэх хугацааг тооцох журмыг өөрчилсөн зохицуулалтын утга, зорилгыг тайлбарлан, түүний практик хэрэглээг хууль зүйн тодорхой байдлын зарчимтай уялдуулан үнэлнэ.
4. Үндсэн хуулийн Цэц болон Улсын Дээд Шүүхийн тайлбар хоорондын зөрчил, тэдгээрийн хууль хэрэглээнд үзүүлж буй нөлөөллийг шүүн тунгааж, эрх зүйн тогтвортой байдлын асуудлыг хөндөнө.
5. мөрдөн шалгах ажиллагааны шатанд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хэргүүд хаагдаж буй практикийг судалж, прокурорын байгууллагын тайлан, статистикт дүн шинжилгээ хийх замаар хууль хэрэглээний бодит үр дагаврыг тоон баримтад тулгуурлан үнэлнэ.
6. Эцэст нь, Франц, Герман зэрэг улс орнуудын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг харьцуулж судлан, Монголын хууль тогтоомжийг боловсронгуй болгох онол, практикийн үндэслэл бүхий санал, загвар дэвшүүлэх зорилт тавигдсан болно.

### **Судалгааны арга зүй**

Энэхүү судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд онолын болон хэрэглээний шинж чанар бүхий олон талт арга зүйг ашигласан болно. Нэн түүрүүнд, судалгааны сэдвийн агуулга нь эрх зүйн онол, хууль зүйн шинжлэх ухаан, хууль хэрэглээний практикт хамаарах тул онолын дүн шинжилгээний арга үндсэн суурь болж ажилласан. Энэ арга нь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинжийг онолын түвшинд задлан тайлбарлах, материаллаг болон процессын шинжийг ялган тодорхойлох, мөн хөөн хэлэлцэх хугацааны талаарх гадаадын эрдэмтдийн бүтээл, олон улсын баримт бичгийн утга агуулгыг задлан шинжлэхэд ашиглагдсан.

Мөн түүхэн судалгааны арга нь Монгол Улсад хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хэрхэн хөгжиж ирсэн талаарх ойлголтыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. 1926, 1942, 1961, 2002, 2015, 2017, 2020 оны Эрүүгийн хуулиудыг харьцуулан судалж, зохицуулалтын өөрчлөлтийн чиг хандлага, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох зорилгоор ашигласан.

Хууль хэрэглээний зөрчил, практикийн бодит байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор эмпирик дүн шинжилгээний арга хэрэглэсэн. Үүнд Прокурорын

байгууллагаас гаргасан мөрдөн шалгах ажиллагааны статистик тайлан, хэрэг бүртгэл, хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн тоон мэдээлэлд үндэслэн анализ хийж, хөөн хэлэлцэх хугацаанаас шалтгаалан хэргийн явц зогсох нөхцөл, шалтгаан, хувь хэмжээг судалгааны баримт болгон ашигласан. Мөн Монгол Улсын эрх зүйн орчныг Франц, Герман, зэрэг улс орнуудын эрх зүйн тогтолцоотой харьцуулан судлахад харьцуулсан эрх зүйн арга чухал үүрэг гүйцэтгэсэн. Уг арга нь гадаад орны туршлага, зарчим, зохицуулалтын үр нөлөөг Монголын нөхцөл байдалтай харьцуулан үнэлж, сайжруулах боломж, чиг хандлагыг тодорхойлоход хэрэглэгдсэн. Түүнчлэн системчилсэн шинжилгээний арга ашигласнаар хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой хууль тогтоомж, Цэцийн дүгнэлт, Дээд шүүхийн тайлбар, мөрдөн шалгах шатны хэрэглээ зэрэг олон төрлийн эх сурвалжуудыг нэгдмэл үзэл баримтлалын үүднээс уялдуулан судалсан. Иймд дээрх арга зүйг хавсран хэрэглэснээр энэхүү судалгаа нь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтыг онол-практикийн нэгдэл бүхий үндэслэлтэйгээр шинжлэх боломжийг бүрдүүлж, шийдэл дэвшүүлэх суурь нөхцөлийг хангаж байнг

## I БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ

### 1.1 Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны онол түүхэн уламжлал эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт

Гэмт хэрэгтэнд хариуцлага хүлээлгэж болох тодорхой хугацааг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэнэ. Энэ нь гэмт хэрэг үйлдсэнээсээ хойш тухайн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө хуульд заасан хариуцлага хүлээхээс зориуд зайлсхийх үйлдэл хийгээгүй, түүнээс хойш хуульд тусгайлан заасан хугацааны дотор дахин ямар нэгэн гэмт хэрэг үйлдээгүй нь нотлогдвол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн ойлголт юм (Алтангэрэл, 2006, р. 241)

Аль ч онолын үзэл баримтлалаас авч үзсэн гэмт хэргийг “хөөн хэлэлцэх хугацаа” гэх ойлголтыг гэмт этгээдийг ял завшуулах хэрэгсэл болгож болохгүй гэсэн үзэл санаа давхар агуулагдаж явдаг. (О.Адъяа, 2022, хууд. 52 ) (Сувд, 2009)

(ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, 2012)

Харин эрүүгийн эрх зүйд “хугацаа” гэдэг ойлголт дараах үндсэн төрлүүдэд хуваагддаг. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа гэмт хэргийн бүрэлдэхүүнд шууд хамаарах, хууль зүйн зохицуулалт, шийтгэл тооцоход зайлшгүй баримтлах хугацаа.
- Эрүүгийн хуулийн үйлчлэх хугацаа – тухайн гэмт хэрэгт аль үеийн хууль үйлчлэхийг тогтоох хугацааны хүрээ.
- Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа – гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш эрүүгийн хариуцлагад татах эрх зүйн хугацааны дээд хязгаар.

Эдгээр хугацаа нь эрүүгийн эрх зүйн материаллаг болон процессын зохицуулалттай салшгүй холбоотой бөгөөд тус бүрийг онолын хувьд ялган авч үзэх шаардлагатай байдаг (С.Нарангэрэл, 2006; Ж.Амарсанаа, 2011).

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг онолын үүднээс авч үзвэл, гэмт хэрэг нь үйлдэгдсэн мөчөөс эхлэн хуулийн хариуцлагын процесс эхлэх боломжтой болохыг илэрхийлдэг. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг тогтоох нь эрүүгийн эрх зүйд олон талаараа чухал ач холбогдолтой. Нэгдүгээрт, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа нь тухайн хэрэгт хамаарах хууль зүйн зохицуулалтыг тодорхойлох үндсэн суурь болдог. Хоёрдугаарт, хөөн хэлэлцэх хугацааг зөв тооцох суурь нөхцөл болдог. Гуравдугаарт, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа нь нотлох баримтуудын үнэн зөв байдлыг тогтоох, процессын ажиллагааг эхлүүлэхэд нөлөөлдөг. (Сувд, 2009, хууд. 115)

Эрүүгийн эрх зүйн хүрээнд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаан нь тодорхой хугацаа өнгөрсний дараа тухайн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болохыг илэрхийлдэг ойлголт юм. Энэхүү зохицуулалт нь хууль зүйн олон улсын зарчим, шударга ёсны шаардлага, хүний эрхийг хамгаалах үндсэн чиг хандлагуудтай нягт уялддаг.

Хөөн хэлэлцэх хугацааг тогтоох нь гэмт хэргийн улмаас бий болсон эрх зүйн тодорхойгүй байдлыг бууруулах, нотлох баримтын үнэн зөв байдлыг хамгаалах, хүний эрхийг баталгаажуулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар хууль зүйн онолын маргаан өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа бөгөөд хуульчид, эрдэмтэд өөр өөрсдийн үзэл баримтлалтай хэвээр байна. Зарим судлаачид хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хуулийн суурь институт гэж үзэж, гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой хугацааны дараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх нь хуулийн шударга байдлын илрэл гэж тайлбарладаг бол нөгөө хэсэг нь хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэгтэн ял завших боломжийг бүрдүүлдэг гэж үздэг. Тодруулбал, Академич С.Нарангэрэл *Монголын эрх зүйн эх толь бичиг* бүтээлдээ “хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн эрх зүй дэх институтийн нэг, хэрэв шүүн таслах ажиллагаанаас зайлсхийгээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацаа” гэж тодорхойлжээ (Нарангэрэл, С, 2006, хууд. 241). Энэ нь гэмт хэрэг үйлдэгчийг тодорхой хугацааны дараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хуулийн механизм хэмээн үзсэн онолын тайлбар юм.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд *Эрүүгийн хуулийн тайлбар* бүтээлдээ “гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй (хөөн хэлэлцэх) хугацааг хуульчилсан явдал бол гэмт хэрэг үйлдсэнээс хойш уг этгээдийг илрүүлж, эрүүгийн хариуцлагад таталгүй урт хугацаа өнгөрсний дараа хуульд заасан болзол бүрдсэн нөхцөлд хэрэг хуучирсан буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх нь хууль ёсны үндэслэл юм” гэж тайлбарласан байна (Г.Совд, 2009, р. 112). Тэрээр гэмт хэрэг үйлдсэнээс хойш илрэхгүйгээр хуульд заасан хугацаа өнгөрөх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг алдагдуулдаг гэж үзсэн байна. Академич Ж.Амарсанаа *Хууль зүйн тайлбар толь* бүтээлдээ “эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааг хуульд заасан тодорхой хугацаа өнгөрч, хуулиар тодорхойлсон нөхцөл байдал бий болсон үед эрүүгийн хариуцлага буюу шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үгүйсгэгдэх нөхцөл байдал” гэж тайлбарлажээ (Ж.Амарсанаа, 2011, хууд. 318)

Энэ нь хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах чухал эрх зүйн зохицуулалт болохыг илэрхийлж байгаа бөгөөд. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь хууль зүйн тодорхой байдал, хүний эрхийг хамгаалах, шүүн таслах ажиллагааны шударга ёсыг хангах үүднээс чухал үүрэгтэй. Хэрэв хөөн хэлэлцэх хугацаа байхгүй бол гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхойгүй хугацаанд эрүүгийн хариуцлагын дарамтад байж, хууль зүйн тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэй. Гэвч хэт богино хугацаагаар тогтоох нь гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших нөхцөлийг бүрдүүлэх сөрөг талтай.

Хөөн хэлэлцэх хугацааны тухай шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, гэсэн хоёр ойлголт бий. шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тайлбарлавал, гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд шүүхээс ял шийтгэл оногдуулах бөгөөд уг шүүхийн шийдвэр хуульд заасан тодорхой хугацаанд биелэгдээгүй байхыг ойлгоно. Энэ нь гэхдээ зөвхөн ялтны хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас шалтгаалсан байх ёстой байдаг. Харин Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг нь гэмт хэрэг илэрсэн ч хэрэгтэн баригдаагүй байх, баригдсан ч тодорхой шалтгааны улмаас хэрэг шалган шийдвэрлэгдэхгүй явсаар хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр тухайн хэргийг хаадаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг тодорхой заасан байдаг. Энэхүү зохицуулалтаар гэмт хэргийн ангиллаас хамааран хөөн хэлэлцэх хугацааг ялгаатай тогтоосон бөгөөд энэ нь эрүүгийн хариуцлагыг ялгавартай хэрэглэх, гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэх үндэслэл болдог. Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 32.2 дугаар зүйлд зааснаар хэрэв хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзнэ.

Хөөн хэлэлцэх хугацааны хэрэгжилт хууль хэрэглээний түвшинд тодорхойгүй байдлыг үүсгэх нь элбэг байдаг. Тухайлбал, шүүхийн таслан шийтгэх тогтоол биелэх хугацаа дууссанаас үүдэн ял завших эрсдэл гарах боломжтой. Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээд удаан хугацааны дараа илэрсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хаах нь шударга ёсны зарчимд харшилж болзошгүй.

Эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо нь хууль зүйн практик, шударга ёс, хуулийн тогтвортой байдлыг хангах чухал зарчим юм. Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалт нь эх газрын эрх зүйн бүлийн улс

орнуудад түгээмэл хэрэглэгддэг. Харин жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь маш хязгаарлагдмал байдаг бөгөөд хуулийн дагуу зөвхөн хүнд гэж тооцогддоггүй хэргүүдэд хэрэглэх боломжтой байдаг. “

Дундад зууны Европын эрх зүйд энэ ойлголт улам боловсронгуй болж, орчин үеийн эрүүгийн эрх зүйд тогтсон дүрэм болсон. Францад хөөн хэлэлцэх хугацааны институцийг хувьсгалаас өмнөх хууль тогтоомжид буюу 1791 оны кодекс-д тусгаснаар хэрэглэгдэж, Францын "Наполеоны Эрүүгийн хууль" болон Германчууд Ромын эрх зүйг хүлээн зөвшөөрсөн үеэс хөөн хэлэлцэх хугацааны тогтоол бий болж. (Roxin, 2006, p. 530)

Монгол Улсын хувьд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт олон жилийн турш өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ нь эрүүгийн бодлого, эрх зүйн тогтвортой байдал, улс төрийн нөхцөл байдалтай нягт уялдаатай байдаг. Монгол Улсад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь түүхийн явцад олон удаа өөрчлөгдөж, хууль тогтоомжийн шинэчлэлтийн хүрээнд боловсронгуй болсоор ирсэн. Энэхүү зохицуулалт нь уламжлалт эрх зүйн тогтолцооноос эхлэн социализмын үеийн хууль тогтоомж, ардчилсан шинэчлэлд тулгуурлан хөгжсөн бөгөөд өнөөгийн эрүүгийн эрх зүйн салшгүй хэсэг болсон. (Цогт, (2010)

Монголын эзэнт гүрний үед батлагдсан "Их засаг" хууль нь эрүүгийн эрх зүйн салбарт чухал зохицуулалт болж, гэмт хэргийг хүнд, хөнгөн гэж ангилах зарчмыг агуулж. Энэ үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хатуу чанд мөрдөгдөж, ихэнх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцогдгүй байсан. (Оюунгэрэл, (2014).)

Энэхүү хуульд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар заасан бөгөөд таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тоолох журмыг хуульчлаагүй. (БНМАУ Шүүх цаазын бичиг, 1926)

(Бнмау шүүх цаазын бичиг, 1929)

((Монгол Улсын Эрүүгийн хууль, , 1942).)

1990 оны ардчилсан өөрчлөлтийн дараа Монгол Улсад зах зээлийн эдийн засагт суурилсан ардчилсан тогтолцоо бүрэлдэж, Үндсэн хуулийн шинэчлэл хийгдсэн. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хууль нь хүний эрхийг дээдэлсэн зарчмыг хууль зүйн тогтолцооны суурь болгон тодорхойлсон бөгөөд үүний үр дүнд 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааны талаар дараах байдлаар заасан. Үүнд (Монгол улсын эрүүгийн хууль, 1961)

- 72.2. Хэрэв этгээд хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө санаатайгаар шинэ гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг хамгийн сүүлд үйлдсэн гэмт хэргийн өдрөөс дахин эхлэн тоолно (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002, 72-р зүйл).
- 72.3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт, шүүхийн шатанд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, тухайн этгээд баригдсан буюу өөрөө илэрч ирсэн өдрөөс эхлэн сэргээн тоолно (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002, 72-р зүйл).
- 72.4. Цаазаар авах ял оноож болох гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. (Монгол улсын эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацаа, түүний онол практикийн зарим асуудал) Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг өөр төрлийн ялаар солих зохицуулалттай (Монгол Улсын Эрүүгийн хууль, 72-р зүйл, 2002)
- 72.5. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, геноцид, дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй ((Монгол Улсын Эрүүгийн хууль 72-р зүйл)., 2002) Энэхүү зохицуулалтаар яллагдагч мөрдөн шалгах, шүүхийн шатанд оргон зайлсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоох зохицуулалт орж ирсэн бөгөөд энэ нь эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн өөрчлөлт болсон. 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэгдэж, 2017 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү шинэчлэлтээр хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн нийгэмд үзүүлэх хор уршгаас хамааруулан ялгамжтай тооцох, зарим төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх зохицуулалт орсон. Тухайлбал, бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байхаар хуульчилсан. (Эрүүгийн эрх зүйн онол, 2021) 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс бус, яллагдагчаар татах хүртэл тооцохоор хуульчилсан нь маргаан үүсгэсэн тул, 2019 өөрчлөлт оруулж өөрчлөлтөөр хөөн хэлэлцэх хугацааг хэрэгт холбогдсон этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэсэн өдрөөс эхлэн тоолохоор хуульчилсан. Энэ зохицуулалт нь эрүүгийн шударга ёсыг хангах, хүний эрхийг хамгаалах, гэмт этгээд ял завших боломжийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт болсон. Монгол Улсад хөөн хэлэлцэх хугацааны асуудал сүүлийн жилүүдэд хууль зүйн маргаантай сэдэв болсоор ирсэн.

2015 оны Эрүүгийн хууль нь 2017 оны 7 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон бөгөөд энэ хуулийн 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааны талаар дараах байдлаар зохицуулсан:

1.10.1. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа нь дараах байдлаар тооцогдоно:

- Хорих ялын дээд хэмжээ 1 жилээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг – 1 жил
- Хорих ялын доод хэмжээ 1 жилээс дээш, дээд хэмжээ 8 жил хүртэлх хугацаагаар тогтоосон гэмт хэрэг – 5 жил
- Хорих ялын доод хэмжээ 5 жилээс дээш, дээд хэмжээ 15 жил хүртэлх хугацаагаар тогтоосон гэмт хэрэг – 12 жил
- Хорих ялын доод хэмжээ 12 жилээс дээш, дээд хэмжээ 20 жил хүртэлх хугацаагаар тогтоосон гэмт хэрэг – 20 жил
- Бүх насаар хорих ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй  
(Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл), 2015)

1.10.2. Хэрэв этгээд хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө санаатай гэмт хэрэг үйлдвэл сүүлд үйлдсэн гэмт хэргийн өдрөөс эхлэн шинэ хөөн хэлэлцэх хугацаа тоологдоно  
(Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл, 2015)

1.10.3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн шалгах, шүүхийн шатнаас оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсож, тухайн этгээд баригдах хүртэл тооцохгүй  
(Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл), 2015)

1.10.4. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, геноцид, дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. (Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл, 2015)

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөөн хэлэлцэх хугацааг ял оногдуулах боломжит хугацаанаас хамааруулан тооцохоор хуульчилсан. 2017, 2020 онуудад хөөн хэлэлцэх хугацааны талаар дахин өөрчлөлт орж, зарим тохиолдолд буцаан тоолох нөхцөл бүрдсэн. Энэ нь эрх зүйн тодорхой байдал, хууль хэрэгжилтийн түвшинд ихээхэн маргаан үүсгэсэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2020 онд гаргасан дүгнэлтээр хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зарим зохицуулалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн. Энэ нь эрүүгийн эрх зүйн суурь зарчим болох "хууль буцаан үйлчлэхгүй байх" зарчмыг зөрчиж байгаа эсэх талаар олон шүүмжлэл дагуулсан. хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо нь хүний эрхийг хамгаалах, хууль зүйн тодорхой байдлыг хангах, нийгмийн шударга ёсыг тогтоох зэрэг олон талт зорилготой.

Хүснэгт. 1.1. 2002, 2015 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны гол ялгаа. 2002, 2015 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны гол ялгаа.

Үзүүлэлт	2002	2015
Хөөн хэлэлцэх хугацааны ангилал	6 сар	1 жил
Хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах хөөн хэлэлцэх хугацаа	5 жил	5 жил
Хүнд гэмт хэрэгт хамаарах хөөн хэлэлцэх хугацаа	15 жил	12 жил
Онц хүнд гэмт хэрэгт хамаарах хөөн хэлэлцэх хугацаа	25 жил (ь, тт)	20 жил
Бүх насаар хорих ялтай гэмт хэрэг	Шүүх шийдвэрлэнэ	Хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй
Гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдвэл	Шинэ гэмт хэрэг үйлдсэнээс тоолно	Шинэ гэмт хэрэг үйлдсэнээс тоолно
Оргон зайлсан тохиолдолд	Хөөн хэлэлцэх хугацаа зогсоно, баригдсан өдрөөс сэргээн тоолно	Хөөн хэлэлцэх хугацаа зогсоно, баригдсан өдрөөс сэргээн тоолно
Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа	Тооцохгүй	Тооцохгүй

Эх сурвалж: (Эрүүгийн хууль, 2002, 2015)

## 1.2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн агуулга ба 2020 оны нэмэлт, өөрчлөлтийн утга, зорилго

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид туссан хөөн хэлэлцэх хугацаа хэмээх институтын эрх зүйн утга нь нэг талаас эрүүгийн хариуцлагыг төрийн зүгээс тодорхой хугацаанд хэрэгжүүлэх, энэ хугацаанд хязгаарлалт тавьснаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нөгөө талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү шуурхай, үр дүнтэй зохион байгуулах зорилготой билээ. ((Ганбат, 2021)

Монгол Улсын Эрүүгийн хууль (2015)-ийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг ял шийтгэлийн дээд хэмжээг үндэслэн ялгавартай тогтоосон бөгөөд энэ нь гэмт хэргийн аюултай байдал, шинж чанарт нийцсэн, харьцангуй нарийвчилсан зохицуулалт юм.

Үүний дагуу:

- Хорих ялын дээд хэмжээ нэг жил хүртэл хугацаатай бол нэг жил;
- Хорих ялын дээд хэмжээ нэг жилээс таван жил хүртэл бол таван жил;
- Хорих ялын дээд хэмжээ таван жилээс арван жил хүртэл бол арван жил;
- Хорих ялын дээд хэмжээ арван жилээс хорин таван жил хүртэл бол арван таван жил;
- Хорих ялын дээд хэмжээ хорин таван жилээс дээш бол хорин жил байна

2015 оны хуулийн зохицуулалт нь хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох, уг хугацааны дотор эрүүгийн хэргийг хэрхэн хянан шийдвэрлэх талаар тодорхой заалт агуулаагүй байсан нь хууль хэрэгжилтийн практикт тодорхойгүй байдал үүсгэж, эрх зүйн маргааныг бий болгосон. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацаа хэрэг үүсгэснээс хойш тоологдох эсэх, эсвэл өөр тодорхой мөчлөгөөс эхлэх үү гэдэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, шүүхийн шатанд зөрчилдөөн үүсгэж байсан бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших боломжийг нэмэгдүүлж, шударга ёсны зарчимд сөргөөр нөлөөлж байсан тул. Энэхүү тодорхойгүй байдлыг арилгах зорилгоор 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Уг өөрчлөлтөөр 1.10 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт: “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл тоолно” хэмээн нэмж тусгасан ( Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль., 2020)

гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолдог байсан зохицуулалтыг өөрчилж уг хугацааг яллагдагчаар татах хүртэл тооцох шинэ зохицуулалтыг бий болгосон. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял завших эрсдлээс ангид байлгах, прокурорын хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, эрүүгийн шүүхийн процессын ачааллыг оновчтой хэмжээнд барих зорилгыг агуулсан Мөн хуулийн этгээд холбогдсон гэмт хэрэг, тэр дундаа татвараас зайлсхийх гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт практикт тодорхойгүй, ойлгомжгүй байдалд хүргэж байсан асуудлыг уг өөрчлөлтөөр тодорхой болгосон. Үүний үр дүнд

дээрх төрлийн гэмт хэргүүдийн хувьд эрх зүйн тодорхой байдал хангагдаж, хууль хэрэгжилтийн үр нөлөө сайжрах нөхцөл бүрдсэн.

Гэвч энэхүү шинэчлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг үр дагавар авчирсан. Тухайлбал, яллагдагчаар татсан өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа зогсох зохицуулалт нь мөрдөн шалгах ажиллагааны үргэлжлэх хугацааг тодорхой хэмжээгээр хязгаарлах боловч яллагдагчаар татах шийдвэр гаргах хугацаа хэт удааширсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дуусч, хэргийг хэрэгсэхгүй болгох нөхцөл үүсэх эрсдэлтэй. Нөгөөтэйгүүр, яллагдагчаар татах үйлдэл хийгдмэгц хөөн хэлэлцэх хугацаа шууд зогсдог тул мөрдөн шалгах болон прокурорын байгууллагуудад хэргийг шийдвэрлэхэд хэт өндөр дарамт, шахалт үүсгэж, зарим тохиолдолд хүний эрхийн зөрчил гарах эрсдэл нэмэгдсэн ((Ганбат, 2021)

Энэ өөрчлөлт нь хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг шинэчлэн тогтоосон хэдий ч, уг зохицуулалт нь хууль хэрэглээний түвшинд тодорхойгүй байдлыг бүрэн арилгаагүй бөгөөд шүүхийн практикт маргаан дагуулах нэг хүчин зүйл хэвээр байна. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох, энэ хугацааг буцаан хэрэглэж болох эсэх асуудал нь хууль зүйн ангилал материаллаг эсвэл процессын шинж дээр маргаан үүсгэсэн бөгөөд . Өмнөх хугацаа тоолох зохицуулалт нь тодорхойгүй байдлаас үүдэн олон эрүүгийн хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болж, улмаар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ял завших, шударга ёсны зарчим алдагдах нөхцөл бүрдсэн . Үүний үр дүнд хууль тогтоогч 2020 оны өөрчлөлтөөр хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл хугацаагаар хязгаарлаж, ял завших боломжийг хязгаарлах зорилт тавьсан боловч шинэ зохицуулалтын хэрэглээнд дахин тодорхойгүй байдал бий болсон.

Энэ тодорхойгүй байдал нь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинж чанартай шууд холбоотой бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагын материаллаг эрх зүйн хэм хэмжээ мөн үү, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын эрх зүйн хэм хэмжээ мөн үү гэсэн асуудал онолын болон практикийн маргааныг өдөөсөн.

Эрх зүйн хэм хэмжээг материаллаг эрх зүй болон процессын эрх зүй гэсэн хоёр үндсэн ангилалыг задлан тайлбарлавал . Энэ ангилал нь хэм хэмжээний эрх зүйн шинж чанар, хэрэглээний хүрээ, хууль буцаан хэрэглэх эсэх зэрэг олон чухал асуудлыг тодорхойлох суурь зарчим болдог. Хөөн хэлэлцэх хугацаа аль ангилалд хамаарах вэ гэдэг асуудал нь онолын болон практикийн түвшинд маргаан үүсгэдэг.

Материаллаг эрх зүй гэдэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял хариуцлагын нөхцөл, хориглох болон зөвшөөрөх үйлдлүүд, ял шийтгэлийн төрөл, хэмжээ зэрэг хүний эрх зүйн байдлыг шууд тогтоодог хэм хэмжээг хэлнэ.

Материаллаг эрх зүйн зохицуулалтад эрүүгийн хариуцлагын үндсэн зарчим багтдаг бөгөөд гэмт хэрэгтний эрх, үүрэг, хариуцлагыг шууд тодорхойлдог.

Хэрэв хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж үзвэл, энэ хугацаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх суурь нөхцөл болно. Тиймээс уг хугацаа дууссан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй бөгөөд энэ зохицуулалт нь хүний эрх зүйн байдлыг шууд өөрчилдөг. Иймд материаллаг эрх зүйн хэм хэмжээний нэгэн адил хууль буцаан хэрэглэгдэхгүй бөгөөд зөвхөн гэмт хэрэг үйлдсэн үеийн тухайн үеийн хуулиар асуудлыг шийдвэрлэнэ.

Процессын эрх зүй гэдэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм, журам, дэглэмийг тодорхойлдог хэм хэмжээнүүдийг хэлнэ. Үүнд мөрдөн шалгах ажиллагаа, ял төлөвлөх, шүүхийн хэлэлцүүлэг явуулах журам, нотлох баримтын бүрдүүлэлт, хугацаа тооцох зарчим зэрэг асуудлууд орно. Процессын хэм хэмжээ нь хууль хэрэгжүүлэх байгууллагуудын ажиллагааны хүрээг зохицуулдаг бөгөөд хүний эрх зүйн байдлыг шууд биш, шууд бус байдлаар нөлөөлдөг.

Хэрэв хөөн хэлэлцэх хугацааг процессын эрх зүйн хэм хэмжээ хэмээн үзвэл, энэхүү хугацаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, дэг журмыг зохицуулсан процессын хугацааны зохицуулалтын нэг хэлбэр болно. Энэ төрлийн хэм хэмжээнд шинээр өөрчлөлт орсон тохиолдолд тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа үед шинэ журмыг шууд хэрэглэх боломжтой байдаг. Энэ нь процессын эрх зүйн хэм хэмжээг хууль буцаан хэрэглүүлэх боломжтой гэсэн нийтлэг зарчимд хамруулдаг. Ийм байдлаар процессын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд шинэ зохицуулалтыг буцаан хэрэглэж болох нь хууль буцаан үйлчлэх зарчмыг материаллаг эрх зүйтэй харьцуулахад харьцангуй уян хатан байлгадаг. Учир нь процессын журам нь хүний эрх зүйн байдалд шууд нөлөөлөхөөс илүүтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохион байгуулалтыг зохицуулдаг тул шинэчлэлт, өөрчлөлт гарсан нөхцөлд түүнийг хэрэглэх боломжийг нээлттэй орхидог.

Тухайлбал, хэрэв хэрэг мөрдөн шалгах буюу шүүхийн шатанд шийдвэрлэгдэх явцад хөөн хэлэлцэх хугацааг шинэчлэн тогтоосон процессын зохицуулалт хүчин төгөлдөр болсон бол уг хугацааг шинэ журамд нийцүүлэн хэрэглэх эрх зүйн боломжтой.

Ингэснээр тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинэ хугацааны зохицуулалтыг шууд хэрэглэх нь процессын эрх зүйн хэм хэмжээний хэрэглээний онцлог гэж үздэг.

### **1.1 Улсын дээд шүүх болон Үндсэн хуулийн Цэцийн байр суурийн үзэл хандлага**

Энэхүү маргааны хүрээнд Үндсэн хуулийн Цэц болон Улсын Дээд Шүүхээс харилцан адилгүй байр суурь илэрхийлсэн. Үндсэн хуулийн Цэц 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтээр хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн шинжтэй гэж үзсэн бол, Улсын Дээд Шүүх 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор уг хугацааг процессын шинжтэй гэж тайлбарласан. Ийнхүү хоёр эрх бүхий байгууллагаас гаргасан зөрүүтэй тайлбар нь хөөн хэлэлцэх хугацааны хэрэглээний талаар эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэж, шүүхийн практикт нэгдсэн ойлголтгүй нөхцөл байдлыг бий болгож байгаа юм. Үндсэн хуулийн Цэц энэхүү зохицуулалтыг эрүүгийн хариуцлагын материаллаг шинжтэй хэм хэмжээ гэж үзсэн бөгөөд түүнийг процессын хэм хэмжээний хүрээнд авч үзэхийг эрх зүйн онол болон практикийн түвшинд ноцтой зөрчил үүсгэнэ гэж үзсэн (Чимэд, 2015)х. 92).

Хамгийн чухал нь энэхүү хуулийн өөрчлөлт нь хэдийгээр онолын болон практикийн хувьд тодорхой байдлыг бий болгох зорилготой байсан ч, эргээд хуулийн хэрэглээнд шинэ маргаан үүсгэж, эрх зүйн тодорхойгүй байдлыг нэмэгдүүлсэн нөхцөл байдлыг бий болгосон. Улмаар энэ нь нэг талаас гэмт хэрэгтний эрхийг хамгаалах, нөгөө талаас шударга ёсыг сахиулах үндсэн зорилтуудыг аль аль талыг хангахад хүндрэл учруулсан (Ганбат, 2021, х. 29-30).

Энэ утгаараа 2020 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь эрх зүйн тодорхой байдлыг хангахаас илүүтэйгээр эрх зүйн системийн онол, практикт шинээр маргаан үүсгэж, Улсын Дээд Шүүх болон Үндсэн хуулийн Цэц хоорондын тайлбарын зөрүүтэй байдлыг бий болгосон.

“Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл тоолно” хэмээх Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь өмнөх зохицуулалтад тодорхойгүй байсан хугацаа тоолох журмыг илүү нарийвчлан хуульчилсан боловч, эрх зүйн онолын хувьд зөрчилдөөн үүсгэж, практик хэрэглээнд хүний эрхийн баталгааг хангах тодорхой бус нөхцөл байдал бий болгосон.

Энэ өөрчлөлт нь хөөн хэлэлцэх хугацааны үр нөлөөг сулруулж, яллагдагчаар татах шийдвэрийг удаашруулах замаар ял завших боломжийг бий болгох эрсдэлтэй хэмээн үзсэн бөгөөд үүний улмаас уг зохицуулалт Үндсэн хуулийн суурь зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах шаардлага гарсан. Улмаар энэ асуудал Үндсэн хуулийн Цэцийн

хяналтын хүрээнд хэлэлцэгдсэн. Үндсэн хуулийн Цэц 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 12 дугаар дүгнэлтийг гаргаж, дээрх зохицуулалтын Үндсэн хуультай нийцэлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд. Цэцийн дүгнэлтийн гол агуулга нь хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах үр дагавартай, улмаар “хууль буцаан үйлчлэхгүй байх” зарчмыг зөрчиж болзошгүй, эрх зүйн тодорхой байдал алдагдахад хүргэж байна. (ҮХЦ, 2020 оны 12 сарын 25, 12 дугаар дүгнэлт).

Үндсэн хуулийн Цэц нь Эрүүгийн хуульд оруулсан хөөн хэлэлцэх хугацааны тооллыг яллагдагчаар татах хүртэл хязгаарласан зохицуулалтыг Үндсэн хуулийн суурь Үндсэн хуулийн Цэц нь Эрүүгийн хуульд оруулсан хөөн хэлэлцэх хугацааны тооллыг яллагдагчаар татах хүртэл хязгаарласан зохицуулалтыг Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэхдээ дараах заалтуудыг эрх зүйн үндэслэл болгон хэрэглэсэн.

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсад хууль дээдлэх, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны суурь зарчим болохыг тунхагласан. Цэц уг зохицуулалт нь шударга ёсны зарчимд харшлах, эрх зүйн тодорхойгүй байдал бий болгох эрсдэлтэй болохыг дүгнэсэн.

Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улс олон улсын гэрээг сахин биелүүлэх үүрэгтэй бөгөөд, ялангуяа хүний эрхийн тухай олон улсын гэрээнд тусгагдсан зарчмуудыг дотоод хууль тогтоомжид нийцүүлэх үүрэг хүлээсэн. Эрүүгийн эрх зүйд хүчин төгөлдөр үйлчилдэг *lex mitior* буюу яллагдагчид ашигтай хуулийг буцаан хэрэглэх зарчим нь олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн болохыг Үндсэн хуулийн Цэц тэмдэглэсэн. Гэвч хөөн хэлэлцэх хугацааны энэхүү зохицуулалт нь уг зарчмыг алдагдуулах нөхцөл бүрдүүлж байгааг Цэцийн дүгнэлтэд тодорхой илэрхийлсэн.

Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг илэрхийлсэн. Цэцийн дүгнэлтэд яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацаа тоолох нь ижил нөхцөл байдалд орших этгээдүүдэд ялгаатай хууль хэрэглээний үр дагавар үүсгэж, тэгш байдлын зарчимд зөрчилдөж байгааг онцолсон.

Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын төр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах үүрэгтэйг заасан. Цэцийн дүгнэлтэд, хөөн хэлэлцэх хугацаа хэрхэн тоологдох нь тодорхойгүй байх нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, тухайн этгээдийн эрх зүйн байдлыг урт хугацаагаар тодорхойгүй байдалд оруулах сөрөг үр дагавар бий болохыг дурдсан.

Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг Хууль нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалтай нийцсэн байх шаардлагатай. Цэцийн дүгнэлтээр, хөөн хэлэлцэх хугацааны энэхүү зохицуулалт нь эрх зүйн тодорхойгүй байдал бий болгож, эрх зүйн тогтолцоонд итгэх итгэлийг бууруулах сөрөг үр дагавартай хэмээн үнэлсэн.

Үндсэн хуулийн Цэц уг дүгнэлтээр хууль тогтоогчид хандан, хөөн хэлэлцэх хугацааны тооллын зохицуулалтыг эрх зүйн тодорхой байдал, шударга ёс, хүний эрхийн баталгааг хангах зарчимд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн эрх зүйн байр суурийг илэрхийлсэн. Гэвч Цэцийн энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаандаа бүрэн тусгаагүй, улмаар шүүхийн практикт нэгдмэл бус хэрэглээ, тайлбарын зөрчил үүсэх нөхцөл бүрдсэн.

Судлаач Ч.Чимэд (2015) өөрийн “Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлууд” бүтээлдээ хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагын материаллаг шинжтэй хэм хэмжээ болохыг онцолж, түүнийг процессын журмын хүрээнд тайлбарлах оролдлого нь хууль зүйн онол болон хэрэглээний зөрчлийг бий болгодог хэмээн шүүмжилсэн байдаг (Чимэд, Ч., 2015, х. 92). Мөн судлаач Ж. Ганбат (2021) “Хуульч” сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлдээ Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн ач холбогдлыг тодруулан, энэхүү дүгнэлт бол зөвхөн нэг удаагийн хуулийн хэрэгжилтийн асуудал биш, харин эрх зүйн системийн дотоод зохицолд нийцэл, шүүхийн практикийн тогтвортой байдал, хүний эрхийн баталгааг хангах институцийн түвшний чухал үнэлгээ болохыг тэмдэглэсэн байна (Ганбат, Ж., 2021, х. 27–29).

Ийм байдлаар Цэцийн дүгнэлт нь эрх зүйн үндсэн тогтолцоонд үзүүлж буй байр суурь, онолын үр дагавар, хууль тогтоогчийн үүрэг, хууль хэрэглээний нэг мөр байдлыг хангах асуудлыг олон талаас авч үзсэн эрх зүйн өндөр ач холбогдол бүхий шийдвэр байсан боловч, Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн үр нөлөөг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан явдал нь зөвхөн нэг шийдвэрийн хууль зүйн хэрэгжилтийг зогсоосон асуудал биш юм. Харин ч эсрэгээрээ, Үндсэн хуулийн дээд хяналтын байгууллагын хууль зүйн байр суурийг үл хэрэгсэх нь эрх зүйн засаглалын тогтолцооны суурь зарчимд сөргөөр нөлөөлөх урт хугацааны эрсдэл үүсгэсэн. Цэцийн дүгнэлт бол Үндсэн хуулийн суурь зарчмуудын агуулгад нийцүүлэн хууль тогтоомжийн агуулга, хэрэглээний нэг мөр байдлыг хангахыг эрх зүйн хүрээнд шаардсан дээд түвшний чиглэлийг илэрхийлсэн баримт юм. Үүнийг хууль тогтоох байгууллага үл ойшоосноор шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын дунд эрх зүйн агуулгын тогтолцоо

алдагдаж, ижил нөхцөл байдалд харилцан адилгүй шийдвэр гарах байдал бий болж байна.

Хүснэгт 1.2 Үндсэн хуулийн цэц гомдол

№	Гомдол гаргагч тал	Гомдлын гол агуулга	Эрх зүйн үндэслэл, суурь асуудал	Холбогдох хууль, заалт	Цэцийн байр суурь
1.	Иргэн Н.Ариунболд (Чингэлтэй дүүрэг, 3-р хороо)	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргийг дахин шалгах нь шударга ёсны зарчимд харшилж, эрүүгийн хариуцлагын материаллаг шинж алдагдаж байна.	Материаллаг эрх зүйн зохицуулалтыг процессын мэт болгосон нь Үндсэн хуулийн 14, 19 дүгээр зүйлд нийцэхгүй.	Үндсэн хууль, Нэгдүгээр зүйл (шударга ёс, ардчилсан ёс); Арван дөрөвдүгээр зүйл (хууль, шүүхийн өмнө эрх тэгш байдал); ICCPR 14-р зүйл (шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрх)	Гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн. Хөөн хэлэлцэх хугацаа нь материаллаг эрх зүйн шинжтэй бөгөөд буцаан хэрэглэж болохгүй.
2.	Иргэн Э.Түмэнбаяр, Б.Баяраа	Хууль буцаан үйлчилж, шүүгдэгчид ашигтай байх ёстой зарчим (lex mitior) зөрчигдөж байна.	Lex mitior зарчим алдагдаж, олон улсын гэрээ (ICCPR 15-р зүйл) зөрчигдөж байна.	ICCPR, 15-р зүйл (аюулгүй байдал, ял завшихаас сэргийлэх); Монгол Улсын Үндсэн хууль, Аравдугаар зүйл (олон улсын гэрээг сахин биелүүлэх)	Lex mitior зарчим зөрчигдөж байгаа нь хүний эрхийн баталгааг алдагдуулж байгааг тогтоосон.
3.	Иргэн Д.Оросоо (Сүхбаатар дүүрэг, 8-р хороо)	Хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох нь процесс удааширч, хүний эрхийг хязгаарлаж байна.	Шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрх зөрчигдөж, Үндсэн хуулийн 19-р зүйл зөрчигдөж байна.	Үндсэн хууль, Арван есдүгээр зүйл (төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үүрэгтэй); ICCPR, 14-р зүйл (шударга шүүхээр	Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь эрх зүйн тодорхойгүй байдал бий болгож, хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

				шийдвэрлүүлэх эрх)	
4.	Иргэн Х.Нямдорж (Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо)	Хууль тогтоох байгууллага хугацааг буцаан хэрэглэж болох мэт зохицуулалт хийснээр хууль зүйн тодорхой байдал алдагдаж байна.	Хууль зүйн тогтвортой байдал алдагдаж, хууль тогтоох эрх мэдэл хэт өргөжсөн — Үндсэн хуулийн 10, 26 дугаар зүйлд нийцэхгүй.	Үндсэн хууль, Далдугаар зүйл (хууль Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцэх); Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль	Хууль тогтоогчийн үйлдэл Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж буйг тогтоосон.

(Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 04 дүгээр дүгнэлт (Дүгнэлт №03).)

Дээрх хүснэгтэд тусгагдсан гомдол, маргаанууд нь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын хүрээнд эрүүгийн эрх зүйн материаллаг болон процессын хэм хэмжээний ялгаа, хэрэглээний хүрээ дээр төвлөрч буйг харуулж байна. Үндсэн хуулийн Цэц эдгээр маргааныг хянан шийдвэрлэхдээ хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн шинжтэй зохицуулалт хэмээн үзэж, *lex mitior* зарчмыг дагаж мөрдөх шаардлагатай гэсэн байр суурийг баримталсан нь олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй нийцэж буйг нотолсон.

Гэвч энэ дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурал бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөлгүй, хууль тогтоох бодлогын хүрээнд өөрийн байр суурийг илэрхийлсэн. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцохдоо, хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох зохицуулалт нь авлига, албан тушаалын гэмт хэргийг үр нөлөөтэй шалгах, ял завших нөхцөлийг хязгаарлах зорилготой болохыг тайлбарласан. УИХ энэхүү зохицуулалтыг батлахдаа НҮБ-ын Авлигын эсрэг конвенц зэрэг олон улсын гэрээний үүргийг биелүүлэх зорилгоор хууль тогтоох онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэсэн болохыг онцолсон.

Хууль тогтоогчийн тайлбар нь эрүүгийн эрх зүйн онол, хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, ялангуяа *lex mitior* зарчмыг хангах талаарх гүнзгий дүн шинжилгээгүй, зөвхөн хууль тогтоох байгууллагын бодлогын шийдвэрийн хүрээнд хязгаарлагдсан байдалтай байв. Үндсэн хуулийн Цэц болон Улсын Их Хурал хооронд эрүүгийн эрх зүйн зохицуулалтын шинж чанарын талаарх байр суурийн суурь зөрчилдөөн үүсч, энэ нь

шүүхийн практикт тодорхойгүй байдал, зөрчилтэй хэрэглээ бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн.

### **1.3.2 Улсын Дээд Шүүхийн тайлбар ба түүний мөрдөн шалгах шатанд үзүүлж буй нөлөө**

Монгол Улсын Их Хурал хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад хууль тогтоох онцгой бүрэн эрхийн хүрээнд тайлбар өгч, энэхүү зохицуулалтыг батлахдаа эрүүгийн бодлогын хүрээнд ял завших нөхцөлийг хязгаарлах зорилготой гэдгийг илэрхийлсэн боловч, Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлттэй зөрчилдөх байдал үүссэн. Үүний үр дагаварт, шүүхийн практикт хоёрдмол тайлбар бүхий, нэгдмэл бус хэрэглээ үүсэх нөхцөл бүрдэж, хуучин болон шинэ зохицуулалтыг аль нь хэрэглэх вэ гэсэн асуудал гарсан. Үүний улмаас шүүхүүд харилцан адилгүй шийдвэр гаргах нөхцөл бий болсон бөгөөд, нэг хэсэг шүүхүүд шинэ хуулийг дагаж мөрдөж, хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тооцсон бол, нөгөө хэсэг нь өмнөх байдлаар тооцож, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосоор байсан. Энэ нь шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдал алдагдах эрсдэлийг бий болгосон.

Монгол Улсын Дээд Шүүхээс 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдөр “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар” гаргаж, хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинж, хэрэглээний хүрээг тодорхойлсон. Уг тайлбар нь эрх зүйн орчинд гүнзгий маргаан, практик зөрчил үүсэх нөхцөлийг улам бүр лавшруулсан дүгнэлт байсан бөгөөд. Дээд Шүүхийн тайлбарт Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа нь нэг талаас эрүүгийн хариуцлагын үндэс болсон хугацааны дээд хязгаарыг тогтоож буй материаллаг шинжтэй, нөгөө талаас уг хугацааг “гэмт хэрэг үйлдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл” тоолох хэлбэрээр процессын шинжтэй зохицуулалт хослон багтсан гэж дүгнэсэн ((Улсын Дээд Шүүх, 2022).)

Улсын Дээд Шүүхийн тайлбар нь хууль зүйн тодорхой байдлыг хангах, хэрэглээний нэгдмэл байдлыг зорьсон гэж тайлбарлагдаж байгаа ч, энэхүү хосолсон үзэл баримтлал нь онолын болон практик түвшинд олон сөрөг үр дагаврыг үүсгэж эхэлсэн. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааны хэрэглээг материаллаг болон процессын хэм хэмжээ гэж зэрэгцүүлэн авч үзсэн нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн суурь зарчимтай нийцэхгүй, эрх зүйн дотоод логик, уялдаа холбоог алдагдуулсан тайлбар. Судлаач Ч.Чимэд энэ талаар “хөөн хэлэлцэх хугацаа нь гэм буруутай этгээдэд оногдуулж болох ялыг цаг хугацааны хүрээнд хязгаарлаж өгсөн, эрүүгийн хариуцлагын материаллаг

шинжтэй үндсэн зохицуулалт” хэмээн тодорхойлсон байдаг ((Чимэд, Ч., 2015, х. 92).  
)Харин уг хугацааг тоолох аргачлалыг процессын зохицуулалт мэт тайлбарлах нь эрүүгийн эрх зүйн суурь ангиллыг гажуудуулахад хүргэж байна.

Уг тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар авч үзвэл, шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагын хооронд хөөн хэлэлцэх хугацааны ойлголт, хэрэглээний нэгдмэл бус байдал улам гүнзгийрсэн. Улсын Дээд Шүүхийн тайлбарын хамгийн их шүүмжлэл дагуулсан нэг асуудал бол олон улсын эрх зүйн зарчимтай үл нийцэж байгаа явдал юм. Олон улсын эрүүгийн эрх зүйн практикт хөөн хэлэлцэх хугацаа нь материаллаг шинжтэй хэм хэмжээ гэж үзэх нь нийтлэг бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, шүүгдэгчид ашигтай хуулийг буцаан хэрэглэх (*lex mitior*) зарчмыг хангах суурь шаардлагатай уялддаг ((Rome Statute of the International Criminal Court, , 1998, Art. )Гэтэл Улсын Дээд Шүүх хөөн хэлэлцэх хугацааны тоолох журмыг процессын шинжтэй хэмээн тайлбарлаж, үүнийг буцаан хэрэглэх боломжгүй болгосон нь олон улсын эрх зүйн стандарттай зөрчилдөж байгаа юм.

Энэхүү тайлбарын практик үр дагавар нь зөвхөн онолын маргаанаар хязгаарлагдахгүй, харин бодит амьдралд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой зөрчил үүсгэж байна. Тухайлбал, 2021 онд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх “Хөгжлийн банк”-тай холбоотой Г-21/10 дугаар хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул хэрэгсэхгүй болгосон бол, Улсын Дээд Шүүхийн тайлбар гарсны дараа уг хэргийг анхан шатны шүүхэд буцаан, ял оноох шийдвэр гаргасан. Үүнтэй адилаар, Ховд аймгийн Цагдаагийн даргатай холбоотой Т-20/45 дугаар хэрэгт шүүхийн шатуудад ялгаатай шийдвэр гарсан бөгөөд энэ нь ижил нөхцөлд хоёр өөр хууль хэрэглээний жишээ болж байна.

Эдгээр практик жишээнүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заасан "хуулийн өмнө тэгш байх" зарчим, Нэгдүгээр зүйлд заасан "хууль дээдлэх" зарчмыг ноцтой зөрчиж буйг харуулж байна. Нэг төрлийн гэмт хэрэгт холбогдсон, ижил нөхцөл байдалтай яллагдагчдын хувьд зарим нь хэрэгсэхгүй болж, зарим нь ял сонсож байгаа нь шүүхийн шийдвэр гаргалтад нэгдмэл байдал алдагдсан, шударга ёсны зарчим алдагдаж буй тод илрэл юм. (Монгол Улсын Үндсэн хууль. (1992). Улаанбаатар: Улсын Их Хурал. Шүүхийн шийдвэрийн цахим сан. (2021). Г-21/10 ба Т-20/45 дугаар хэргүүдийн шийдвэрүүд. <http://www.shuukh.mn>)

Үүнээс гадна, шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын хооронд хөөн хэлэлцэх хугацааны ойлголтын зөрүү улам гүнзгийрч, мөрдөн шалгах шатны

ажиллагаанд тодорхойгүй байдал үүсгэж байна. Мөрдөгч, прокурор нар хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох, хэргийн үргэлжлэх эсэх талаар тогтвортой ойлголтгүй, шүүхийн шийдвэрээс хамааралтайгаар байр сууриа өөрчилж байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь хуулийн хэрэглээний тодорхойгүй байдалд хүргэж, гэмт этгээдүүдийн ял завших, эсвэл мөрдөн шалгах байгууллагын зүгээс хууль бусаар ял оноох эрсдэл үүсгэж байгаа юм. ((Ганбат, Ж., 2021, х. 28-29).)

Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбар нь хөөн хэлэлцэх хугацааны материаллаг ба процессын шинж чанарын талаарх байр суурийг давхар агуулсан хэдий ч, уг зохицуулалтын хууль зүйн шинж чанарыг онолын хувьд нэгдмэл байдлаар тодорхойлоогүй нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд бодит зөрчилдөөн үүсгэсэн. Тус тайлбар нь хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хариуцлагын материаллаг шинжтэй элемент бөгөөд процессын хэм хэмжээнд давхар хамааралтай хэмээн дүгнэсэн боловч, энэ байр суурь нь хууль зүйн тодорхой байдал, нэг мөр хэрэглээний зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Ялангуяа эрүүгийн эрх зүйд мөрдөгддөг *lex mitior* буюу шүүгдэгчид ашигтай хуулийг буцаан хэрэглүүлэх зарчмыг бүрэн хангаагүй бөгөөд энэ нь хүний эрхийн баталгаанд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Уг тайлбар нь эрүүгийн хариуцлагын бодлогын үндэс болсон материаллаг хэм хэмжээ болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг зохицуулсан процессын хэм хэмжээг онолын хувьд нэгдмэл дүгнэлтгүй орхигдуулсан бөгөөд, энэ нь хууль хэрэглэгчдэд хоёрдмол ойлголт, зөрүүтэй практик бий болгох суурь нөхцөлийг хангаж байна.

### **Хэсгийн дүгнэлт**

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хариуцлагын үргэлжлэх хугацааг хууль ёсоор хязгаарлах замаар хүний эрхийг хамгаалах, эрх зүйн тодорхой байдал, шүүхийн ажиллагааны үр нөлөөг хангах механизм болдог. Энэхүү хугацаа нь хууль зүйн шинжлэх ухааны үүднээс материаллаг эрх зүйн хэм хэмжээ мөн эсэх талаар онол-практикийн маргаан олон улсын болон дотоодын түвшинд тасралтгүй явагдсаар ирсэн бөгөөд.

Эрүүгийн эрх зүйн онолын түвшинд уг хугацаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хариуцлага хүлээх эрх зүйн боломжийг хугацаагаар хязгаарлах тул эрүүгийн хариуцлагын эрх зүйн үндэс болж, материаллаг шинжтэй гэж үзэх нь зонхилсон байр суурь юм. Энэхүү дүгнэлт нь академик С.Нарангэрэл, Ж.Амарсанаа, Ч.Чимэд, Г.Совд

нарын судалгаанд нотлогдож, хүний эрх зүйн байдалд шууд нөлөө үзүүлдэг хэм хэмжээний ангилалд хамаарна гэж үзсэн байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2002, 2015, 2020 оны найруулгуудыг харьцуулж судалсан үр дүнгээс харахад хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хууль зүйн үр нөлөө, ялгамжтай хэрэглээний зарчим, төрийн хариуцлагын бодлого, хариуцлага хүлээлгэх боломжийг нарийвчлан тогтоох гэсэн оролдлого байсан ч хууль хэрэглээний практикт зөрчил, хоёрдмол ойлголт бий болгож.

2020 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “гэмт хэрэг үйлдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл тоолох” гэж хуульчилсан нь хөөн хэлэлцэх хугацааг процессын шинжтэй хэм хэмжээ болгон тайлбарлах үндэслэл болж, шүүхийн практикт эрүүгийн эрх зүйн ангиллын үндсэн зарчимтай зөрчилдсөн.

Үндсэн хуулийн Цэц 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дүгнэлтээр энэхүү хугацаа нь материаллаг шинжтэй хэм хэмжээ хэмээн үзэж, *lex mitior* буюу яллагдагчид ашигтай хуулийг буцаан хэрэглүүлэх олон улсын эрх зүйн зарчимтай нийцүүлэн тайлбарласан. Харин Улсын Дээд Шүүх 2022 оны 3 дугаар сарын 9-ний тайлбартаа уг хугацаа нь “материаллаг болон процессын шинжийг хавсарсан зохицуулалт” гэж үзсэн нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг ангилах онолын үндсэн логиктой зөрчилдөж, шүүх, прокурор, мөрдөн шалгах шатанд нэг мөр хэрэглээний боломжийг үгүй хийсэн.

Энэхүү маргаан нь зөвхөн хууль зүйн онолын асуудал бус бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль хэрэглэх нэгдмэл байдал алдагдах, ял завших нөхцөл бүрдэх, шударга ёс, эрх зүйн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх бодит шалтгаан болсон.

Хууль хэрэглээний зөрүүг харуулсан Г-21/10, Т-20/45 зэрэг бодит хэрэгт гарсан шүүхийн шийдвэр нь ижил нөхцөлд харилцан эсрэг шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж, Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн “хуулийн өмнө тэгш байх” зарчим зөрчигдөж, хүний эрхийн баталгааг хангах нөхцөлгүй болж байна.

Иймд энэхүү бүлгийн судалгааны үндсэн дүгнэлт дараах байдалтай байна:

1. Хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагын материаллаг шинжтэй хэм хэмжээ бөгөөд хүний эрх зүйн байдалд нөлөөлдөг учир хууль буцаан үйлчилж үл болно.

2. Эрүүгийн хуулийн 2020 оны нэмэлт, өөрчлөлтөөр хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолохоор хуульчилсан нь эрх зүйн онолын хүрээнд процессын хэм хэмжээ мэт ойлголт үүсгэж, хууль зүйн тодорхой байдлыг алдагдуулсан.
3. Үндсэн хуулийн Цэцийн байр суурийг Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаандаа бүрэн тусгаагүй нь Үндсэн хуулийн дээд хяналтын институцийн байр суурийг үл хүндэтгэсэн ноцтой нөхцөл байдлыг бий болгосон.
4. Улсын Дээд Шүүхийн “хосолмол шинжтэй” тайлбар нь онолын суурь логиктой нийцэхгүй бөгөөд шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг алдагдуулж, ял завших, хүний эрх зөрчигдөх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.
5. Иймд Монгол Улсад хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинжийг тодорхойлохдоо онолын цэвэр байдлыг баримтлан, материаллаг хэм хэмжээ болохыг хүлээн зөвшөөрөх, шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагуудын нэг мөр хэрэглээний нөхцөлийг хууль тогтоомжийн төвшинд бүрдүүлэх шаардлагатай байна.

## II. БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ

2.1 Хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн процессын эрх зүйн үүднээс авч үзэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь зохицуулалт

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь зөвхөн эрүүгийн хуулийн материаллаг эрх зүйн хүрээнд бус, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамаарал бүхий процессийн шинжтэй асуудал юм. Учир нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тооцох, зогсоох, сэргээх, дуусгавар болгох зэрэг бүх үйл ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтад багтаж, тухайн хэргийг шийдвэрлэх процессын явцад үүсдэг.


Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1.3.6-д “шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах” нь хуулийн зорилго хэмээн заасан бөгөөд үүнийг хангахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үндэслэлтэй, хугацаандаа, үр дүнтэй явагдах нь зайлшгүй шаардлага болдог. Гэтэл сүүлийн жилүүдэд мөрдөн байцаалт удааширч, яллагдагчаар татах ажиллагаа хэт хойшлогдон, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох нь элбэг тохиолдож байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашиггүй байдал.

Хүснэгт 2.1 Эрүүгийн хэргийн бүртгэл 2024 Улсын хэмжээнд

Үзүүлэлт	Тоон үзүүлэлт	Хувь (%)
Бусад /шийдвэргүй,явцтай гэх мэт/	74,438	59.44%
Хэрэг бүртгэлийн хэрэг хаасан	18,285	24.56%
Яллагдагчаар татсан	11,912	16.00%

Эх сурвалж: (Прокурорын Хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын статистик, 2024)

Зураг 2.1 Эрүүгийн хэргийн бүтгэл, шийдвэрлэлт



Эх сурвалж: (Прокурорын Хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын статистик, 2024)

Жилийн эцсийн тайлан мэдээг хүснэгтээр харуулбал улсын хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нийт гэмт хэргийн ихэнхи хувийг хэрэгсэхгүй болгосон байна. Хэргийг хэрэгсэхгүй болгох хуулийн хэдэн хэдэн үндэслэл байдаг бөгөөд үүний дотор "Хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн зохицуулалттай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол (ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ 1.5, 2017)

Дараахь тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй:

- 1.1.гэмт хэргийн шинжгүй;
- 1.2.Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан;
- 1.3.яллагдагч, шүүгдэгч нас барсан /нас барсан хүнийг цагаатгах, эсхүл бусад хүнд холбогдох шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас уг хэргийг сэргээж хянан шийдвэрлэх ажиллагаа үүнд хамаарахгүй/;
- 1.4.тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа;
- 1.5.тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон. (ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ 1.5, 2017)

- Тэгэхээр хэргийг хэргэсгүй болгох хүчин зүйлийн нэг нь яах араггүй "Хөөн хэлэлцэх хугацаа"-ны асуудал юм. Хэрэв тухайн хэрэг прокурорын хяналтад буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байх хугацаанд эсвэл шүүхийн шатанд хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан бол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Прокурорын байгууллагын практикийг судалж жилд хэдэн хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байна вэ гэдгийг олж тогтооход практик судалгааны ач холбогдол оршино

2015 оноос өмнөх Эрүүгийн хуулиудад хөөн хэлэлцэх хугацааны тасрах, зогсох, түдгэлзэх, сэргээх үндэслэлийг зохицуулсан ч, нарийвчилсан зохицуулалт байхгүй байсан бөгөөд. Одоо үйлчилж буй Эрүүгийн хуулинд хөөн хэлэлцэх хугацааны тасрах, зогсох, түдгэлзэх, сэргээх үндэслэл, түүний эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй байхаас гадна хөөн хэлэлцэх хугацааг буруу тогтоосон нь эрх зүйн хийдэл үүсгэх, гэмт этгээдэд ял завших боломжийг олгосон.


Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацаа нь ялын дээд хэмжээгээр тогтоогддог атал Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 болон 1.3 зүйл нь

- 1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; ((Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл), 2015)
- 1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн ((Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл), 2015) хөөн хэлэлцэх хугацаатай байхаар тогтоон хуульчилсан нь гэмт хэргийн санкцийг гэмт хэргийн хэмжээ, шинж, төрлийг харгалзан зөв тогтоож чадаагүй, хөөн хэлэлцэх хугацааг ялын дээд хэмжээгээр тогтоодог атал бага хэмжээгээр тогтоосноос шалтгаалж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох гэмт этгээдэд ял завших боломжийг олгож байна.

## Хүснэгт 2.2 Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн дүн

Гэмт хэргийн төрөл	2023 оны тоо	2024 оны тоо	Өсөлт (%)
Нийт гэмт хэрэг	35 574	44 673	(25.6 %-ийн)
Хөнгөн гэмт хэрэг	31 589	38 953	(23.3 %-ийн өсөлт)
Хүнд гэмт хэрэг	3 985	5 720	(43.5 %-ийн өсөлт)
Гэмт хэргийн төрөл	2023 оны тоо	2024 оны тоо	Өсөлт (%)

## Зураг 2.1 Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нийт дүн 2024, 2025



Эх сурвалж: <https://police.gov.mn/>

## Хүснэгт 1.3 2024 Онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2024 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Бүх гэмт хэрэг		Өсөлт, бууралт %	Гэмт хэргийн ангилал			
						Хөнгөн		Хүнд	
			2023	2024		2023	2024	2023	2024
1	2	3	4	5	6	7			
1		Баян-Өлгий	407	447	9.8	303	323	104	124
2		Говь-Алтай	273	405	48.4	231	296	42	109
3		Завхан	328	285	-13.1	253	204	75	81
4		Үүнээс: Тосонцэнгэл	92	69	-25.0	69	50	23	19
5		Увс	333	348	4.5	263	249	70	99
6		Хөвд	601	676	12.5	512	552	89	124
7		Үүнээс: Булган	103	91	-11.7	89	79	14	12
8		Архангай	397	447	12.6	295	316	102	131
9		Баянхонгор	395	577	46.1	312	454	83	123
10		Булган	392	411	4.8	302	309	90	102
11		Орхон	761	984	29.3	649	828	112	156
12		Өвөрхангай	516	695	34.7	435	502	81	193
13		Үүнээс: Хархорин	163	219	34.4	135	132	28	87
14		Хөвсгөл	600	693	15.5	485	508	115	185
15		Говьсүмбэр	139	186	33.8	121	147	18	39
16		Дархан-Уул	714	982	37.5	633	822	81	160
17		Дорноговь	677	828	22.3	570	649	107	179
18		Үүнээс: Замын-Үүд	209	236	12.9	184	195	25	41
19		Дундговь	246	282	14.6	217	236	29	46
20		Өмнөговь	725	790	9.0	645	638	80	152
21		Үүнээс: Цогтцэций	434	414	-4.6	399	338	35	76
22		Сэлэнгэ	726	870	19.8	631	679	95	191
23		Үүнээс: Мандал	201	236	17.4	174	167	27	69
24		Төв	688	804	16.9	579	628	109	176
25		Үүнээс: Заамар	144	161	11.8	119	116	25	45
26		Дорнод	533	646	21.2	446	476	87	170
27		Сүхбаатар	456	497	9.0	373	372	83	125
28		Хэнтий	669	687	2.7	474	520	195	167
29		Үүнээс: Бор-Өндөр	86	99	15.1	71	81	15	18
30		Нийслэл	24978	32123	28.6	22846	29239	2132	2884
31		Баянгол	4456	5974	34.1	4222	5,617	234	357
32		I хэлтэс	2229	3159	41.7	2129	2986	100	173
33		II хэлтэс	2227	2815	26.4	2093	2631	134	184
34		Баянзүрх	6130	8,702	42.0	5644	8,015	486	687
35		I хэлтэс	1981	3515	77.4	1829	3263	152	252
36		II хэлтэс	2512	2716	8.1	2366	2488	146	228
37		III хэлтэс	1637	2471	50.9	1449	2264	188	207
38		Сүхбаатар	3832	4458	16.3	3495	4085	337	373
39		I хэлтэс	2649	3171	19.7	2531	2985	118	186
40		II хэлтэс	1183	1287	8.8	964	1100	219	187
41		Сонгинохайрхан	3385	3898	15.2	2958	3346	427	552
42		I хэлтэс	1612	1747	8.4	1378	1486	234	261
43		II хэлтэс	1009	1196	18.5	900	1001	109	195
44		III хэлтэс	764	955	25.0	680	859	84	96
45		Хан-Уул	3974	5101	28.4	3606	4689	368	412
46		I хэлтэс	2598	3282	26.3	2347	3022	251	260
47		II хэлтэс	1376	1819	32.2	1259	1667	117	152
48		Чингэлтэй	2666	3369	26.4	2465	2957	201	412
49		I хэлтэс	1464	1860	27.0	1396	1698	68	162
50		II хэлтэс	1202	1509	25.5	1069	1259	133	250
51		Багануур	188	286	52.1	159	243	29	43
52		Багахангай	20	20	0.0	19	16	1	4
53		Налайх	327	315	-3.7	278	271	49	44
54		Бусад	20	10	-50.0	14	6	6	4
55		ИАТ	9	6	-33.3	7	6	2	
56		Төмөр зам	48	77	60.4	43	75	5	2
57		Мөрдөн байцаах алба	627	653	4.1	483	411	144	242
58		Эрүүгийн цагдаагийн алба	688	1101	60.0	632	1034	56	67
59		Тээврийн цагдаагийн алба	564	1193	2.1 дах	559	736	5	457
60		Экологийн цагдаагийн алба	120	125	4.2	118	117	2	8
61		Хар тамхитай тэмцэх газар	216	213	-1.4	185	184	31	29
62		НЦДГ-Халаасны хулгай	79	1056	13.4 дах	79	1056		
63		Улсын дүн	35574	44673	25.6	31589	38953	3985	5720
		Өсөлт бууралт/тоогоор/		9099			7364		1735
		Өсөлт бууралт /хувиар/		25.6			23.3		43.5

Дээрх статистик дүнгээс үзэхэд гэмт хэргийн нийт тоо, хөнгөн болон хүнд төрлийн гэмт хэргүүдийн аль аль нь эрс нэмэгдсэн нь мөрдөн шалгах ажиллагааны чанар, хугацаа алдагдах, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусах эрсдэл нэмэгдэж байгаа нь эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж, ял завших нөхцөлийг бүрдүүлж байна.

2020-2024 оны хооронд нэг мөрдөгчид ногдох хэргийн тоо нийслэлд сард 31.1, орон нутагт 12.5 байсан нь олон улсын жишигтэй харьцуулахад өндөр үзүүлэлт бөгөөд мөрдөгч бүр хугацаанд багтаж, нотлох баримт цуглуулах, хэргийг шалган шийдвэрлэх боломжийг хязгаарлаж байна (ЦЕГ, 2024). мөрдөгчдийн ажлын хэт ачаалал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, бүрэн шалгалт хийж чадахгүйд хүргэх, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болох нөхцөлийг бүрдүүлж, байгаа бөгөөд үүнээс яллагдагчид ял завших боломжийг олгож байгаа юм.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны 1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн гэж байгаа нь оногдуулж буй ялтайн ижил түвшнээр хөөн хэлэлцэх хугацааг тоолсон алдаагүй боловч нэг дүүргийг сонгон авч судалгаа хийхэд Баянзүрх дүүргийн 2020.01.01-ний өдрөөс 2024.12.20-ны өдрийн хооронд нийт 38736 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 17111 хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр, 3594 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хаасан байна Үүнээс 17.1, болон 11.6, дийлэнх хувь эзэлж байгааг хархад нэг тэлаас цагдаагын байгууллагын ачаалал нөгөө талаас харицангуй хөнгөн гэмт хэрэг тул прокурор цагдаагс хяналт шалгалт бага байгаан хохирогчийн зүгээс эрхээ эдлэх хангуулах боломж, шударга ёс, ял завшуулахгүй байх гэх зэрэг үндсэн зарчимууд зөрчигдаж байна. Ч.Чимэд (2015)“Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлууд” бүтээлдээ, ял шийтгэл нь гэмт хэрэгтэн, нийгэмд тодорхой үр дагавар бий болгож, хариуцлагыг бодитой хэрэгжүүлэхэд чиглэнэ гэж дурдсан.

Зураг 2.3 Баянзүрх дүүрэгийн хэргэсгүй болсон хэрэг



Эх сурвалж: (Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, 2020-2024)

Хөгжингүй орнууд ялын дээд хэмжээн 1 жил боловч хөөн хэлэлцэх хугацаан хөнгөн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа нь нотлох баримт цуглуулах, хэрэг бүртгэл хийхэд хугацаа шаарддаг гэсэн үндэслэлээр хэдийгээр гэмт хэргийн хор уршиг бага боловч мөрдөн шалгах ажиллагааг бүрэн явуулахад хангалттай хугацаа өгөх нь хариуцлагыг бодитоор хэрэгжүүлэхэд чухал. Тиймээс зарим улс 1 жилийн хорих ялаар ангилагдах хөнгөн гэмт хэрэгт 2-3 жил хүртэл хөөн хэлэлцэх хугацаа тогтоож байгаа атал манай улсын хувьд хөгжил буурай хууль хүчний байгууллагын боловсон хүчин муу нэг цагдаад жилд ноогдож буй хэргийн тоо их нотлох баримт цуглуулан үзлэг нэгжлэг хийхэд прокурорын зөвшөөрөл аван прокурорууд тэр бүр ажил дээрээ байхгүй хорих ангиуд шүүх хурлууд гээд яваад өгөн зөвшөөрөл байхгүй тул үзлэг нэгжлэг мөрдлөг явуулах боломж нь хомс мөрдөгчөөс мөрдөгчийн хооронд нэг хэргийг шилжүүлсээр байтал 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаар байгаад анхаарал хандуулахгүй байгаа нь өөрөө ял шийтгэл зайлшгүй байх ёстой гэсэн зарчмыг алдагдуулж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1.1-д “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хууль ёсны эрхийг хүндэтгэн, хамгаалах” талаар тусгасан нь үйл явц удааширснаар хохирогч шударга ёсонд нөлөөлж, сэжигтэн хуулийн хугацааг ашиглан хэрэгсэхгүй болох боломжтой гэдгийг. Ийм нөхцөл нь эрх зүйн хүний эрхийн зөрчилд нөлөөлж байна

2.2 Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжинд хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгасан байдал

гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгасан байдал нь Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм. Улс орнуудын туршлагаас харвал хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, түүний тооллыг эхлүүлэх, түдгэлзүүлэх, зогсоох, сэргээх зэрэг асуудлуудыг харилцан адилгүй зохицуулсан байдаг. Энэ нь тухайн улс орны эрх зүйн тогтолцоо, гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, хүний эрхийн хамгааллын түвшинтэй холбоотой байдаг.

Тухайлбал, зарим оронд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн шинж чанар, хор уршиг, нийгэмд учруулсан аюулын зэргийг харгалзан ялгаатай байдлаар тогтоодог.

### **Герман Улсад**

Германы хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн тогтолцоо нь олон зууны түүхтэй бөгөөд хамгийн эртний хууль тогтоомжууд нь Германы эзэнт гүрний (Deutsches Kaiserreich, 1871–1918) үеэс эхтэй. Энэ хугацаанд эрүүгийн хариуцлагын тухай үзэл баримтлал хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулан ялгавартайгаар тогтоох зарчмыг тодорхойлсон байдаг. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн шалтгаан, онцлог, үйлдсэн этгээдийн байдал зэрэг олон хүчин зүйлээс хамааран тогтоодог нь эрх зүйн ойлголтонд өргөн хэрэглэгддэг бөгөөд тухайн үеийн хууль тогтоомж нь эдүгээ ч үргэлжилж байна.

ХБНГУ нь эрх зүйн шинжлэх ухааны салбарт өндөр хөгжсөн бөгөөд түүний Эрүүгийн хуулиар дамжуулан хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг тодорхой зааж өгсөн байдаг.

Германд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо тухайн гэмт хэргийн шинж чанар, нийгэмд үзүүлэх аюулын зэрэг болон түүнд оногдуулж болох ялын төрлөөс хамаарч шатлалтайгаар нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ нь хэрэг бүрийг нэг ижил хугацааны хүрээнд багтаах бус, харин гэмт хэргийн ноцтой байдал, учруулсан хор уршгийг бодитоор үнэлэх эрүүгийн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, шударга ёсны зарчим хэрэгжих нөхцөлийг хангах чухал механизм гэж үздэг.

Уг зохицуулалтын суурь зорилго нь гэмт хэргийн хор уршгийг хууль зүйн үүднээс бодитоор үнэлж, ял завших эрсдэлийг багасгах нь энэ хуулийн үндсэн зорилго

Тодруулбал, Германы Эрүүгийн хуулийн §78-д зааснаар, тухайн гэмт хэргийн ангилал, түүнд оногдуулах хорих ялын дээд хэмжээнээс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоожээ:

Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа

- Насан туршид хорих ялтай гэмт хэрэгт гэмт хэрэг үйлдэгсэнээс хойш 30 жил өнгөрсөн 10 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулдаг гэмт хэрэгт гэмт хэрэг үйлдэгсэнээс хойш 20 жил
- 5-10 жилийн хорих ялтай гэмт хэрэгт – 10 жил
- 1-5 жилийн хорих ялтай гэмт хэрэгт – 5 жил
- 1 жил хүртэл хорих ялтай, мөнгөн торгуультай гэмт хэрэгт – 3 жил
- Зарим зөрчлийн чанартай, хөнгөн гэмт хэрэгт – 2 жил

Дээрх хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэх талаар тусгайлсан зохицуулалтанд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэл төгссөн хугацаанаас эхэлж тоолох боловч хор уршиг гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааруулсан тохиолдолд хор уршигыг илэрсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно

Германы эрүүгийн эрх зүйн онолд "Unvermeidbarkeit der Strafe" буюу "ял шийтгэл зайлшгүй оногдох ёстой" хэмээн тодорхойлдог. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд хариуцлагаас зайлсхийх боломжгүй бөгөөд хууль ёсны үндэслэлээр тухайн этгээдийг шийтгэх зайлшгүй шаардлагатай гэсэн эрх зүйн суурь зарчим юм. Энэ зарчмыг хэрэгжүүлэх нь гэмт хэргийн хариуцлагыг хэрэглэх явцад хууль ёсны бүх талын шударга ёсыг хангах, олон нийтийн итгэлийг сэргээх, нийгмийн зөрчилд зөв хариу арга хэмжээ авахад чиглэгддэг. Түүнчлэн, энэ нь зөвхөн гэмт этгээдийг хариуцлагаас зайлсхийхээс сэргийлэх төдийгүй, шударга ёсны үндсэн үзэл санаа, эрүүгийн хариуцлагын үр дүнг бүрэн хангах чухал механизм болж ажилладаг.

Германы Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд "гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт үйлдэл эсвэл үйлдэхүй төгссөн үеэс эхлэх" (Germany, 2024) гэсэн заалт байдаг. Түүнчлэн, хөөн хэлэлцэх хугацаа зогсох, түдгэлзэх болон хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байх нөхцөлүүдийг мөн нарийн заасан байдаг бөгөөд тэдгээрийг дэлгэрэнгүй хуулиндаа хэрхэн тусгасанг дурдвал.

Германы Эрүүгийн хуульд зааснаар, хөөн хэлэлцэх хугацаа нь тодорхой үйлдлийн улмаас түр зогсож, улмаар тухайн үйлдлийн дараа шинээр тоологдож эхэлдэг. Энэ үйл явцыг “хөөн хэлэлцэх хугацаа зогсох” гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл, хэрвээ гэмт хэрэгт

холбогдуулан төрийн байгууллагаас тодорхой үйл ажиллагаа явуулбал, хугацаа тухайн мөчөөс эхлэн тасалддаг бөгөөд тасалдсан хугацаанаас хойш дахин шинээр тоологддог.

Германы Эрүүгийн хуулийн §78c зүйлд хөөн хэлэлцэх хугацаа зогсох дараах нөхцөлүүдийг тусгасан байдаг. Үүнд:

- Гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх /жишээ нь: мөрдөн шалгах ажиллагаа эхлэх, Сэжигтэн этгээдийг байцаах, мэдүүлэг авах/
- Яллагдагчаар татах тухай шийдвэр гаргах
- Хэргийг шүүхэд шилжүүлж, шүүх хурал товлох
- Шүүх хурлын ажиллагаа эхлэх, эсвэл анхан шатны шүүхийн шийдвэр гаргах
- Эдгээр үйлдэл нь хэргийг шийдвэрлэх явцыг идэвхжүүлсэн гэж үздэг тул тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоох үндэслэл болдог.

Хэдийгээр хугацаа зогссон ч, хязгааргүйгээр үргэлжлүүлэх боломжгүй бөгөөд хуулийн дагуу зогсох үйлдлээс хойш хамгийн ихдээ 5 жилийн дотор шийдвэрлэгдэх ёстой байдаг. Энэ нь гэмт хэргийн хариуцлагыг хэт сунжруулахгүй байх эрх зүйн хамгаалал болж өгдөг. онолын тайлбар дээр Хөөн хэлэлцэх хугацааг зогсоох зохицуулалт нь эрүүгийн процессын идэвхтэй явц буюу мөрдөн шалгах ажиллагаа тодорхой хэмжээнд эхэлсэн, эрх бүхий байгууллагууд хэрэгт бодитой анхаарал хандуулж буйг илэрхийлдэг. Энэ нь нэг талаас гэмт этгээдэд хариуцлага тооцох боломжийг хадгалах, нөгөө талаас хэргийг зориуд сунжруулж, хөөн хэлэлцэх хугацаа дуусахыг хүлээх байдлыг таслан зогсооход чиглэдэг. Энэхүү зохицуулалтын цаад зорилго нь гэмт хэрэгтнүүдийг шүүх хариуцлагаас “цаг хугацааны аргаар зугтаах” боломжийг хязгаарлах, харин нөгөө талаас иргэдийн эрхийг хамгаалах тэнцвэрийг бий болгох явдал юм. Хэрэв төрийн байгууллагууд хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн л бол гэмт этгээдийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр “аврагдах” боломжгүй болгох зорилготой.

### ***Хөөн хэлэлцэх хугацаа түдгэлзэх (Ruhens der Verjährung)***

Хөөн хэлэлцэх хугацаа түдгэлзэх гэдэг нь тухайн хугацааг түр зогсоож, огт тооцохгүйгээр “царцаах” эрх зүйн зохицуулалт юм. Энэ нь тухайн үед хууль сахиулах байгууллагаас хэрэг бүртгэх, мөрдөн шалгах, яллах ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрэглэгдэнэ. Түдгэлзэл нь хугацааг тасалдуулж байгаа ч дараа нь өмнөх хугацаа үргэлжилдэг, харин зогсолт (*Unterbrechung*) нь хугацааг шинээр эхлүүлдэг гэдгээрээ дээрхээс ялгаатай.

Германы Эрүүгийн хуулийн (§78b):

- Хууль ёсны дархан эрх, халдашгүй байдалтай холбоотой тохиолдол Жишээлбэл, хэргийн холбогдогч нь Германы Бундестагийн гишүүн бол хуулиар олгогдсон дархан эрхийн улмаас түүнийг мөрдөн шалгах, яллах боломжгүй байдаг. Энэ үед хөөн хэлэлцэх хугацаа түдгэлзэнэ. (Germany, Strafgesetzbuch, §78b, 2024)
- Хэргийн этгээд гадаадад оргон зайлсан Дипломат эрх, олон улсын гэрээний хориг саад Хэргийн холбогдогч нь дипломат дархан эрхтэй, эсвэл тухайн улс олон улсын эрх зүйн хүрээнд харьяалал, харилцан туслалцааны хоригтой орон байвал мөн л хугацаа түдгэлзэнэ. (Germany, Strafgesetzbuch, §78b, 2024)

Эрх зүйн үндэслэл ба зорилго нь Хөөн хэлэлцэх хугацаа түдгэлзэх зохицуулалт нь хууль сахиулагчид тухайн хэргийг шийдвэрлэх бодит бололцоогүй үед хугацаа явж, хэрэг хөөн хэлэлцэх хугацаанд "дууссан" гэж тооцогдох шударга бус байдлаас сэргийлэх зорилготой бөгөөд. Өөрөөр хэлбэл, тухайн нөхцөл байдал нь төрөөс гэм буруутай этгээдийг яллахад саад учруулсан тохиолдолд, төрийн хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хангахын тулд хугацааг царцаадаг. Энэ нь эрх зүйн онолын үндсэн зарчмууд болох:

- Шударга ёс (Gerechtigkeit)
- Хариуцлагын зайлшгүй байдал (Unvermeidbarkeit der Strafe)
- Эрүүгийн бодлогын үр нөлөө (Effektivität der Strafverfolgung) гэсэн суурь үзэл санаатай нийцдэг.

Хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэгдэхгүй (Unverjährbarkeit) Германы Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, StGB) болон олон улсын эрх зүйд зарим төрлийн онц ноцтой гэмт хэрэгт Unverjährbarkeit буюу хөөн хэлэлцэх хугацаа хэзээ ч тооцоггүй байх зарчим үйлчилдэг. Энэ нь гэмт хэрэг ямар хугацааны өмнө үйлдэгдсэнээс үл хамааран хариуцлага хүлээлгэх боломж үргэлж нээлттэй байдаг гэсэн үг юм. Хөөн хэлэлцэх хугацаа тооцогдохгүй гэмт хэргүүдэд дараах зүйлс хамааруулан үздэг.

Геноцид (StGB §220a) Ард түмнийг бүхэлд нь устгах, эсвэл тодорхой бүлгийг системтэйгээр мөхөөх зорилготой үйлдэл.

Хүний эсрэг гэмт хэрэг (Strafgesetzbuch, §7, 2024)Төрийн зүгээс иргэдийн эсрэг системтэйгээр үйлддэг хүчирхийлэл, боолчлол, хоморголон баривчлах зэрэг үйлдэл.

Дайны гэмт хэрэг Зэвсэгт мөргөлдөөн, дайны үед олон улсын хууль зөрчин үйлдсэн ноцтой гэмт хэрэг, тухайлбал энгийн иргэдийг санаатайгаар хохироох, олзлогсдыг тамлах гэх мэт.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. Хүүхдийн насанд хүрэх хүртэл хөөн хэлэлцэх хугацаа эхлэхгүй байх тусгай зохицуулалттай. ((StGB §78b Abs. 1 Nr. 1), огноо байхгүй)

Зохион байгуулалттай хүчирхийлэл, хүний наймаа, бэлгийн мөлжлөг Эдгээр өндөр эрсдэл бүхий гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг удаашруулах, зарим тохиолдолд бүрэн хасах зохицуулалт үйлчилдэг.

Эдгээр өндөр эрсдэл бүхий гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг удаашруулах, зарим тохиолдолд бүрэн хасах зохицуулалт үйлчилдэг. Энэ нь шударга ёсыг хангах, нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулсан ноцтой гэмт хэргүүдийг ял завших боломжгүй болгох зорилготой Германы эрүүгийн эрх зүйн бодлогын чухал хэсэг юм.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн төрлөөс хамааран ялгамжтай тогтоосон боловч хугацааны хэмжээ нь Германы эрх зүйн тогтолцоотой харьцуулахад хангалтгүй. Монголын Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд зааснаар, 2-8 жилийн хорих ялтай гэмт хэрэгт 5 жилийн, 5-15 жилийн хорих ялтай гэмт хэрэгт 12 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон байдаг ((Монгол Улсын Эрүүгийн хууль 1.10-р зүйл), 2015). Энэ зохицуулалт нь бодит хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангалттай хугацаа олгох боломжийг хязгаарладаг.

Германы Эрүүгийн хуульд (Germany, Strafgesetzbuch, §78, 2024) гэмт хэргийн оногдуулж болох ялын төрлөөс хамаарч хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоодог. (Germany, 2024) Үүнд:

- Насан турш хорих ялтай гэмт хэрэгт – 30 жил
- 10 жилээс дээш хорих ялтай гэмт хэрэгт – 20 жил
- 5-10 жилийн хорих ялтай гэмт хэрэгт – 10 жил
- 1-5 жилийн хорих ялтай гэмт хэрэгт – 5 жил
- 1 жил хүртэл хорих ялтай, мөнгөн торгуультай гэмт хэрэгт – 3 жил
- Зарим зөрчлийн шинжтэй хөнгөн гэмт хэрэгт – 2 жил (Germany, 2024)

Энэхүү тогтолцоо нь гэмт хэргийн ноцтой байдал, нийгмийн хор аюулын түвшинд нийцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг шаталсан бүтэцтэй, илүү уян хатан зохицуулсан байдаг. Тухайлбал, 1 жилийн хорих ялтай гэмт хэрэгт 3 жилийн хөөн хэлэлцэх хугацаа

тогтоосноор эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх бодит боломжийг хадгалж, ял завших эрсдэлээс сэргийлэх зохицуулалтыг бүрдүүлсэн.

Монголын эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоонд хорих ялын дээд хэмжээ 1 жил бол 1 жилийн хөөн хэлэлцэх хугацааны үргэлжлэх хугацаа богино байгаа нь мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх үйл явцад саад учруулах, хөөн хэлэлцэх хугацаа хурдан дуусгавар болох гэмт этгээд ял завших эрсдэлийг нэмэгдүлж байна.

Иймд Монгол Улсын эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг Герман улсын тогтолцооны жишгээр бодит нөхцөл, мөрдөн шалгах ажиллагааны хугацааг харгалзан нэмэгдүүлэх шаардлагатай. Ялангуяа, гэмт хэргийн ноцтой байдал, хор аюулын түвшинг үнэлж, хөөн хэлэлцэх хугацааг шаталсан бүтэцтэй, оновчтой тогтоох нь ял завших боломжийг хязгаарлах, эрүүгийн хариуцлагын механизмын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой

### **Францын эрх зүй**

Германы эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоог судалсны дараа континенталь эрх зүйн өөр нэгэн төлөөлөгч болох Францын туршлагыг авч үзэх нь зүйтэй. Учир нь Германы тогтолцоо нь хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн төрлөөс хамаарч тогтоодог, эрх зүйн тодорхой байдал, төрийн яллах ажиллагааны үр нөлөөг тэнцвэржүүлэх зарчимд суурилдаг бол Францын тогтолцоо үүнээс өөр, өөрийн онцлог бүхий шийдлүүдтэй. Тус улсын эрх зүйн систем нь хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоог боловсронгуй болгож, нарийвчилсан процессийн зохицуулалт, орчин үеийн нөхцөлд нийцүүлсэн шинэчлэлүүдээрээ ялгардаг. (République Française, 2024)

Францын эрүүгийн хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацааны институт нь эртний Ромын эрх зүйгээс гаралтай бөгөөд олон зууны хөгжлийн явцад өөрийн өвөрмөц тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Эртний Ромд төрийн яллах ажиллагааг тодорхой хугацааны дотор хэрэгжүүлэх тухай ойлголт анх үүссэн бөгөөд энэ нь тухайн үеийн эрүүгийн процессийн хугацааны хязгаарлалт, шударга ёс, эрх зүйн тодорхой байдлыг хангах зарчимд үндэслэсэн (Delmas-Marty, 1992). Энэхүү уламжлал Францын эрх зүйн тогтолцоонд дундад зуунаас эхлэн шингэж, 1791 оны эрүүгийн хуулиар анх удаа албан ёсоор хуульчилсан бөгөөд энэ нь хувь хүний эрхийг хамгаалах, төрийн эрх мэдлийг хязгаарлах зорилготой шинэчлэлийн эхлэл болсон (Code pénal de 1791, 1791)

Францын эрх зүй нь континенталь эрх зүйн бүл буюу Ром-Германы бүлд хамаардаг бөгөөд энэ бүлгийн онцлог нь хууль тогтоомжид суурилсан эрх зүйн тогтолцоо байх

явдал юм. (David, 2002) Хууль тогтоомж нь эрх зүйн үндсэн эх сурвалж бөгөөд шүүхийн шийдвэрүүд нь зөвхөн хууль тогтоомжийг тайлбарлах, хэрэглэх хүрээнд үйлчлэх зохицуулалттай.

Энэхүү түүхэн уламжлал, эрх зүйн тогтолцооны боловсронгуй бүтэц нь Францын туршлагыг судлах, Монголын эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад харьцуулалт хийх үндэслэл болдог. Франц нь континенталь эрх зүйн бүлд хамаарах, Монгол Улсын эрх зүйн суурь бүтцийн зарчимтай төстэй тул харьцуулах боломжтой бөгөөд, нөгөө талаас, хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт, хэрэгжилтийн онцлог нь Монголтой ялгаатай тул харьцуулан шинжлэх замаар Монголын эрүүгийн эрх зүйн сул болон давуу талыг илрүүлэх, цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Францын эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацаа нь (République Française, 2024) төрийн яллах ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан тодорхой хугацааны зохицуулалт юм. Энэ хугацаа дууссан нөхцөлд прокурор, хохирогч эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шүүхэд хандах эрхээ алдана. Эрүүгийн процессийн энэ механизм нь зөвхөн хууль зүйн үр дагавартай төдийгүй, шударга ёс, нийгмийн дэг журмыг сахин хамгаалах зарчимд суурилсан бүтэцтэй. (République Française, 2024)

Хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн утга нь хоёр чиглэлд үйлчилдэг.

- Нэгдүгээрт, гэмт хэрэг үйлдэгч этгээдийг тодорхой хугацаанд ял шийтгэлээс ангид үлдээхгүй, хариуцлага хүлээлгэх үүргийг төрд ноогдуулдаг.
- Хоёрдугаарт, энэ үүргийг цаг хугацаагаар хязгаарласнаар эрх зүйн тодорхой байдал, нотолгооны үнэн зөв байдал, хууль ёсны итгэлцлийг хамгаална.

Цаг хугацааны уртад баримт сэлт бүдгэрч, гэрчийн мэдүүлгийн үнэн зөв байдал алдагдах нь хууль ёсны шийдвэр гаргах боломжийг сулруулдаг. Иймд хөөн хэлэлцэх хугацаа нь эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шударга ёсны зарчмыг хамгаалах зорилготой механизм юм. (David R. ,.-S., 2002)Түүнчлэн, хөөн хэлэлцэх хугацаа гэдэг ойлголт нь хувь хүний эрхийг хамгаалах өөр нэг зарчим болох “Хугацаа дууссанаар эрх зүйн дарамтаас чөлөөлөгдөх боломж” (République Française, 2024)тэй салшгүй уялдаатай. Энэ эрх нь хувь хүнийг хэт урт хугацаанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлд байлгахгүй байхыг хангаснаар эрх зүйн тогтвортой байдлыг хангана. Үүний зэрэгцээ, төрийн яллах үйл ажиллагаанд шуурхай шийдвэрлэхийг шаардаж, хяналт тогтоох боломж олгодог.

Францын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааг нийтийн дэг журмыг сахин хамгаалах зарчимтай шууд холбон үздэг бөгөөд (*ordre public*) энэ нь шүүхийн бүх шатны ажиллагаанд тухайн хугацаа дууссан эсэхийг шүүгч өөрийн санаачилгаар хянан шийдвэрлэх үүрэгтэйг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, уг хугацаа нь зөвхөн талуудын хүсэлтээр бус, хууль ёсны журмыг хангахын тулд шүүгчийн санаачилгаар заавал харгалзан үзэгдэх ёстой хүчин зүйл бөгөөд энэ хугацаа дууссан бол эрүүгийн хариуцлагын процессийг үргэлжлүүлэх эрх зүйн үндэс байхгүй болно. Түүнчлэн энэ хугацаа нь тухайн этгээдийн хүсэлтээр зогсоогдох боломжгүй, өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхээс татгалзах, хойшлуулах ямар ч нөхцөл хуульд хүлээн зөвшөөрөгддөггүй.

Францын эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд (*République française, 2023*) дэлгэрэнгүй тусгагдсан бөгөөд тус хуулийн 7-9-3 дугаар зүйлүүдэд хөөн хэлэлцэх хугацааны ангилал, үргэлжлэх хугацаа, тоолох журам, тасалдуулах, зогсоох механизм зэргийг нарийвчлан тодорхойлсон байдаг. Харин ял эдлүүлэх хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь Эрүүгийн хуульд (*Code pénal*) тусгагдсан бөгөөд 133-2-оос 133-6 дугаар зүйлүүдэд энэ талаар тусгайлан заасан. Мөн зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар Эрүүгийн хуулийн 211-1-ээс 212-3 дугаар зүйлүүдэд тусгайлан зохицуулсан байдаг.

Францын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо гэмт хэргийн ангиллыг үндсэн шалгуур болгон хэрэглэдэг бөгөөд. Эрүүгийн хуулиар гэмт хэргийг нийгэмд учруулах хор уршгийн шинж чанар, оногдуулах ялын хэмжээ зэрэгт тулгуурлан:

- хүнд гэмт хэрэг (*crime*),
- хөнгөн гэмт хэрэг (*délit*),
- зөрчил (*contravention*) гэсэн гурван үндсэн ангилалд хуваан ангилдаг. Энэ ангилал нь хөөн хэлэлцэх хугацааг ялгаатайгаар тогтоох үндэс суурь болдог бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бодит боломж, үр дагаврыг хуулийн зарчимд нийцүүлэн зохицуулах чухал үүрэг гүйцэтгэдэг.

хөөн хэлэлцэх хугацааг хоёр үндсэн төрөлд хуваан зохицуулдаг. Үүнд ердийн хөөн хэлэлцэх хугацаа болон тусгай хөөн хэлэлцэх хугацаа хэмээх ялгаа бий. Энэ ангилал нь эрүүгийн хариуцлагын боломжийг гэмт хэргийн хор аюул, шинж чанараас хамаарч

ялгавартайгаар тогтоох, нийгмийн дэг журмыг сахин хамгаалах, хохирогчийн эрхийг хангах, төрийн яллах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготой.

Ердийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн ерөнхий ангилал болох хүнд гэмт хэрэг (crimes), хөнгөн гэмт хэрэг (délits), зөрчил (contraventions)-д харгалзах үндсэн хугацааг тогтооно. Энэ нь Францын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (СРР) 7-9-р зүйлд тусгагдсан бөгөөд бүх төрлийн гэмт хэргийг нийтлэг зарчмаар хамардаг.

Тусгай хөөн хэлэлцэх хугацаа нь ердийн хугацаанаас ангид, тодорхой төрлийн гэмт хэргийн шинж, хор аюулын түвшинг харгалзан хугацааг уртасгах эсвэл богиносгох зорилготой зохицуулалт юм. Энэ төрлийн хугацаа нь терроризм, дайны гэмт хэрэг, зохион байгуулалттай бүлэглэлээр үйлдэгдсэн гэмт хэрэг, насанд хүрээгүй хүний эсрэг хүчиндэх, бэлгийн халдлага, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйлдсэн гүтгэх, доромжлох зэрэгт хамаарна. Илрүүлэх боломж хязгаарлагдмал, нуугдмал шинжтэй эсвэл нийгмийн дэг журамд ноцтой нөлөөтэй гэмт хэргийг ялган, эрүүгийн хариуцлагын боломжийг удаан хадгалах, нөгөө талд хурдан шийдвэрлэх шаардлагатай үйлдлүүдэд хугацааг богино тогтооно. Энэ тогтолцоо нь эрүүгийн хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх, хууль зүйн тодорхой байдлыг хангах зорилготой.

#### Хүснэгт 2.4 Франц улсын хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа

Гэмт хэргийн ангилал	Оногдуулах ял	Хөөн хэлэлцэх хугацаа
Хүнд гэмт хэрэг (Crimes)	15 жилээс бүх насаар хорих ял	20 жил (өмнө нь 10 жил)
Хөнгөн гэмт хэрэг (Délits)	2 жилээс 10 жилийн хорих ял	6 жил (өмнө нь 3 жил)
Зөрчил (Contraventions)	2 сараас доош хорих ял эсвэл торгууль	1 жил

Энэхүү зохицуулалтыг 2017 оны 2-р сарын 27-ны шинэчлэлээр хөөн хэлэлцэх хугацааг уртасгасан бөгөөд хүнд болон хөнгөн гэмт хэргийн хувьд мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах, нотлох баримтыг бүрдүүлэх хугацааг нэмэгдүүлэх зорилгоор хийгдсэн. Энэ нь ял завшихаас урьдчилан сэргийлэх, эрүүгийн хариуцлагын механизмыг бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй өөрчилөлт байсан (СРР, art. 7-9-3).

## Хүснэгт 2.5 Франц улсын хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа

Гэмт хэргийн төрөл	Хөөн хэлэлцэх хугацаа
Терроризм, дайны гэмт хэрэг, зохион байгуулалттай бүлэглэлээр хар тамхи наймаалах	30 жил
Насанд хүрээгүй хүний эсрэг хүчиндэх (хохилогчийг насанд хүрснээс хойш тоолно)	30 жил
Насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн халдлага	20 жил
Насанд хүрээгүй хүний эсрэг хөнгөн гэмт хэрэг (заналхийлэх, бие махбодид хөнгөн хохирол учруулах)	10 жил

## Хүснэгт 2.6 Богино хугацаа (бууруулаагүй тусгай хугацаа):

Гэмт хэргийн төрөл	Хөөн хэлэлцэх хугацаа
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гүтгэх, доромжлох	3 сар
Ялгаварлан гадуурхах шинжтэй хэвлэлийн гэмт хэрэг	1 жил

Францын эрүүгийн хууль тогтоомжид зарим төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэгдэх тусгай зохицуулалт байдаг бөгөөд . Энэ зохицуулалт нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг дагаж, хүн төрөлхтний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргүүдэд хугацааны хязгаарлалт тогтоох боломжгүй гэсэн суурь зарчимд тулгуурладаг. Ийм гэмт хэрэгт геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг зэрэг хамрагддаг бөгөөд эдгээр нь Эрүүгийн хуулийн (Code pénal) 211-1-ээс 212-3 (France, 2024) дугаар зүйлд тусгайлан заагдсан. Үүнд:

- Геноцид (Code pénal, art. 211-1),
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг (Code pénal, art. 212-3) багтана.

- Эдгээр гэмт хэрэг нь нийгмийн нийтлэг ашиг сонирхолд ноцтой хохирол учруулдаг учир хугацааны хязгаарлалтгүйгээр эрүүгийн хариуцлагыг хангах шаардлагатай гэж хууль тогтоогч үзсэн учраас хөөн хэлэлцэх хугацааг тоолдог. Хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам нь Францын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам нь эрх зүйн зарчим болон практик хэрэгжилтийн уялдаа холбоон дээр суурилсан чухал зохицуулалт юм. Энэ журмын хүрээнд хугацааны эхлэх цэг, хугацааг тасалдуулах, хугацааг зогсоох гэсэн гурван үндсэн ойлголт харилцан уялдаатайгаар зохицуулагддаг (Code de procédure pénale, art. 7-9-3). Хугацаа тоолох зарчим нь хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн агуулгыг бодит амьдралд хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болж, эрүүгийн хариуцлагын механизмыг үр ашигтай ажиллуулах, хууль ёсны итгэлцэл, шударга шүүхийн зарчмыг хангах зорилготой. Энэ зохицуулалт нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд тодорхой байдал, тэнцвэрт байдлыг хангах, мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөг зохистой түвшинд хадгалах үндэс суурийг бүрдүүлдэг. Хөөн хэлэлцэх хугацааны эхлэх цэг гэдэг нь эрүүгийн хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх суурь зохицуулалт юм. Энэ нь эрүүгийн эрх зүйн тодорхой байдал, хууль ёсны итгэлцэл, шударга шүүхийн зарчмыг хангах гол нөхцөлийг бүрдүүлдэг. Ерөнхий зарчмаар, хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тоологдог (CPR, arts. 7, 8, 9). Хөөн хэлэлцэх хугацаа эхлэх цэгийг гэмт хэргийн шинж чанар, үйлдлийн хэлбэр, илрүүлэх нөхцөлөөс хамааран эхлэх цэгийг өөрөөр тогтоох зохицуулалт байдаг. Үүнд: 1. Үргэлжилсэн гэмт хэрэг (Infractions continues) Тодорхой хугацаанд үргэлжилсэн хэлбэртэй гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт үйлдэл дууссан өдрөөс эхэлнэ. Жишээлбэл, хууль бус эзэмшил, хүний эрхийн зөрчил үргэлжилсэн нөхцөл зэрэгт хамаарна. Хугацаа нь зөрчил тасалдсан өдөрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолдог.
2. Олон Давтамжтай гэмт хэрэг (Infractions d'habitude) Давтамжтай үйлдэгддэг гэмт хэргийн хувьд хамгийн сүүлчийн үйлдэл нь хөөн хэлэлцэх хугацааны эхлэл цэг болно. Жишээлбэл, гэр бүлийн хүчирхийлэл, давтамжтай дарамт шахалт үзүүлэх гэмт хэрэгт энэ зохицуулалт үйлчилнэ. Давтамжтай үйлдэл нь гэмт хэргийн үргэлжилсэн шинжийг харгалзан
  3. Далд болон нуун дарагдуулсан гэмт хэрэг (Infractions occultes ou dissimulées) Илрэх боломжгүй, эсвэл санаатайгаар нуун дарагдуулсан гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх

хугацаа нь гэмт хэргийг илрүүлсэн өдрөөс эхэлнэ (СРР, art. 9-1). Эдгээр нөхцөлд хугацаа нь гэмт хэрэг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэх боломжтой болсон өдрөөс эхэлнэ тоолдог.

4. Насанд хүрээгүй хүний эсрэг гэмт хэрэг Францын хууль тогтоомжид насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн зарим ноцтой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хохирогч 18 нас хүрсэн өдрөөс эхэлж тоолохыг хуульчилсан. Энэ нь хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэргийн шинж чанараас шалтгаалан илрүүлэхэд тодорхой хугацаа шаардагдах нөхцөлийг харгалзсан зохицуулалт юм. Тухайлбал, насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хувьд энэ зохицуулалт хамаарна.

мөн хугацааг тасалдуулах гэдэг ойлголт нь (Interruption) хугацааг бүрэн зогсоож, тухайн үйлдлийг шинээр хугацаа тоолох механизмыг илэрхийлнэ. Энэ нь төрийн яллах эрхийн хүрээнд идэвхтэй процессийн ажиллагаа хийгдсэн нөхцөлд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломжийг хязгаарлах үүрэгтэй бөгөөд. Тасалдуулах үр дагавар нь Тасалдуулах ажиллагаа явагдсан өдрөөс эхлэн өмнө тоологдсон хугацаа хүчингүй болж, ижил хугацаатай шинэ хугацаа эхэлдэг.

Францын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9-2-р зүйлд хугацааг тасалдуулах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлсон. Үүнд:

- Прокурор, эсвэл хохирогчийн (иргэний нэхэмжлэгчийн хувьд оролцох хүсэлт гаргасан этгээд) зүгээс эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбоотой албан ёсны процессийн ажиллагаа эхлүүлэх.
- Цагдаа, мөрдөн байцаагч, прокурорын байгууллагаас хэрэгжүүлсэн мөрдөн шалгах болон яллах ажиллагаа (жишээ нь, яллагдагчаар татах, шүүхэд дуудах, нэгжлэг хийх, шинжилгээ томилох гэх мэт).
- Шүүхээс гаргасан шийдвэрүүд (шийтгэх, цагаатгах), тэр дундаа эцсийн бус боловч хүчин төгөлдөр шийдвэр.

Тасалдуулах үйлдэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн идэвхтэй оролцоо, эрүүгийн хариуцлагын үргэлжлэх нөхцөлийг хадгалах механизм болдог. Анхаарах онцлог нь энгийн гомдол гаргах (*plainte simple*) нь тасалдуулах хүчинтэй үйлдэлд тооцогддоггүй бөгөөд зөвхөн прокурор, мөрдөн шалгах байгууллагаас албан ёсоор ажиллагаа эхлүүлсэн нөхцөлд хугацаа тасалдуулж болдог.

Хөөн хэлэлцэх хугацааг зогсоох нь тодорхой эрх зүйн нөхцөл байдлын улмаас хугацааны тооллыг түр зогсоож, тухайн нөхцөл арилсны дараа урьд зогссон цэгээс нь үргэлжлүүлэх боломж олгодог зохицуулалт юм. Энэ механизм нь эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан эрх зүйн хязгаарлалт буюу гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл үүссэн үед хэрэгждэг (СРР, art. 9-3).

Францын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9-3-р зүйл нь хугацааг зогсоох дохиолдолуудыг тодорхойлсон Үүнд: Эрх зүйн нөхцөл байдал (Obstacle de droit) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хуульд заасан эрх зүйн үндэслэлээр яллах ажиллагаа явуулах боломжгүй болсон нөхцөлд хугацааг түр зогсооно. Үүнд

- Парламентын гишүүний болон Ерөнхийлөгчийн халдашгүй байдал: Халдашгүй эрх нь тухайн албан тушаалтан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс түр хугацаанд хамгаалагдсан байдлыг илэрхийлнэ. Халдашгүй байдал нь хүчин төгөлдөр байгаагийн улмаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болдог тул хугацаа зогсож, эрхийн хүчин төгөлдөр байдал дууссаны дараа хугацаа үргэлжилнэ.
- Урьдчилан зөвшөөрөл авах шаардлага: Зарим төрлийн гэмт хэргийн хувьд эрүүгийн процесс эхлүүлэхийн өмнө тусгай зөвшөөрөл шаардлагатай нөхцөл бий. Жишээлбэл, дипломат дархан эрхтэн, олон улсын байгууллагын төлөөлөгчтэй холбоотой хэрэгт урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай бол хөөн хэлэлцэх хугацаа зогсоно.
- Урьдчилан шийдвэрлэх асуудал (question préjudicielle): Иргэний хэрэг эсвэл бусад процессоор урьдчилан шийдвэрлэх шаардлагатай эрх зүйн маргаан байгаа тохиолдолд хугацааг зогсооно. Эрүүгийн хэрэг нь тухайн урьдчилан шийдэгдэх асуудлаас хамааралтай нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байдаг тул хугацаа зогсоох зохицуулалт хамаарна.
- Зуучлал, эвлэрүүлэлтийн ажиллагаа: Хуульд заасан зуучлалын буюу эвлэрүүлэх процесс явагдаж буй үед хөөн хэлэлцэх хугацаа зогсоно. Энэ нь, ялангуяа, хөнгөн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хэргүүдэд мөрдөгдөх боломжтой бөгөөд гэмт хэргийн үр дагаврыг эрт хугацаанд шийдвэрлэх, хохирогч, холбогдогчийн эвлэрэлд суурилсан бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Давагдашгүй хүчин зүйл болон эрүүгийн процесс явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хугацаа түр зогсоно. Үүнд Байгалийн гамшиг, дайн байлдаан гэх мэт бодит шалтгаанаас үүдэн прокурорын байгууллага, шүүхийн процесс зогсонги байдалд орж, хэрэг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл бүрдсэн бол хугацаа зогсоно. Энэ зохицуулалт нь хууль ёсны итгэлцлийг хадгалах, хууль зүйн зарчмыг зөв

хэрэгжүүлэхийн зэрэгцээ, үр ашиггүй нөхцөл байдлаас хөөн хэлэлцэх хугацааны дуусгавар болохоос сэргийлэх ач холбогдолтой.

Зарим тохиолдолд хуульд заасан процессын тодорхой хугацаа, журам нь хугацааг зогсоож болно. Тухайлбал, СРР-ийн 175-р зүйлд заасан мөрдөн байцаалт дууссан тухай мэдэгдэх хугацаа нь хугацааг зогсоох боломжийг бүрдүүлэх нөхцөл болж болохыг шүүхийн практикт тайлбарласан байдгаараа онцлог..

2024 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Францын Парламент баталсан 2024-420 дугаар хууль нь эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад суурь өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлтөөр төрийн албан тушаалтны гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг, насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, эрүүгийн хариуцлагын механизмын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Тодруулбал, төрийн албан тушаалтны авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа өмнө нь 6 жил байсныг 10 жил болгон сунгасан (СРР, art. 8). Энэ нь төрийн албаны ил тод байдал, хариуцлагыг хангах, авлигын гэмт хэргийг илрүүлэх нөхцөлийг сайжруулах зорилготой.

Эдийн засгийн гэмт хэрэг, тухайлбал мөнгө угаах, татварын залилан зэрэг хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа мөн 6 жил байсныг 10 жил болгон уртасгасан (СРР, art. 8). Хуулийн энэхүү зохицуулалт нь эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, нотлох баримтыг бүрдүүлэх нөхцөлийг өргөтгөж, хариуцлагын бодит хэрэгжилтийг дэмжих зорилготой.

Мөн насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг өмнө нь 20 жил байсныг 30 жил болгож уртасгасан бөгөөд энэ хугацаа хохирогч насанд хүрсэн өдрөөс эхлэн тоологдох зохицуулалтыг баталгаажуулсан (СРР, art. 7). Энэхүү өөрчлөлт нь хохирогчийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг илрэхэд шаардагдах хугацааг хангах, мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Эдгээр өөрчлөлт нь Францын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд илүү бодитой, уян хатан бүтэц бүрдүүлж, эрүүгийн хариуцлагын механизмын үр нөлөөг хангах, хохирогчийн эрхийг хамгаалах, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд чухал алхам болж байна.

“Францын эрүүгийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь зөвхөн хугацааг тогтоох төдий бус, тасалдуулах болон зогсоох механизмуудаараа онцлог бөгөөд эрүүгийн хариуцлагын хэрэгжилтийг бодит нөхцөлд үр нөлөөтэй хангах боломжийг

бүрдүүлдэг. Тухайлбал, мөрдөн шалгах болон яллах ажиллагаа эхэлсэн нөхцөлд хугацааг бүрэн тасалдуулж, шинээр хугацаа тоолох зохицуулалт, мөн эрх зүйн болон бодит нөхцөл байдлаас шалтгаалан хугацааг түр зогсоож, нөхцөл арилмагц хугацааны тооллыг сэргээх зэрэг нь эрүүгийн процессийн явцад шударга ёс, нотолгооны үнэн зөв байдал-ыг хангах чухал хэрэгсэл болдог.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааны тасалдуулах, зогсоох зохицуулалт харьцангуй хязгаарлагдмал, ерөнхий агуулгатай оршиж байгаа нь зарим тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөг бууруулах, ял завших нөхцөл бүрдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Зогсоох(Suspension): Монголд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох тухай зохицуулалт бараг байдаггүй. Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах явцад тодорхой эрх зүйн болон бодит нөхцөл байдлаас шалтгаалан хугацааг зогсоох (жишээ нь, эрх бүхий этгээдийн халдашгүй байдлаас шалтгаалах, мөрдөн шалгах боломжгүй байдал) нарийвчилсан зохицуулалт дутмаг.

Иймээс Францын адил зогсоох механизмыг илүү боловсронгуй болгон оруулах нь Монголын эрх зүйн хувьд чухал ач холбогдолтой юм. Ялангуяа:

- Парламентын гишүүдийн халдашгүй байдалтай холбоотойгоор хугацааг зогсоох,
- Давагдашгүй хүчин зүйл (дайн, байгалийн гамшиг) үүссэн үед зогсоох,
- Урьдчилан шийдвэрлэх асуудалтай холбоотойгоор хугацааг зогсоох зэрэг зохицуулалтыг Монголын хууль тогтоомжид дэлгэрүүлж оруулах шаардлага бий.

Тасалдуулах(Interruption):

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулах (interruption) тухай зохицуулалт оршдог. Тухайлбал, Эрүүгийн хууль (2015 оны шинэчилсэн найруулга), 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах, шүүхэд хэргийг шилжүүлэх зэрэг гол процессийн ажиллагаагаар тасалдуулна гэж хуульчилсан. Гэвч энэ зохицуулалт нь Францын эрүүгийн эрх зүйн тогтолцоотой харьцуулахад илүү хязгаарлагдмал хүрээнд байдаг бөгөөд. Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Code de procédure pénale, art. 9-2)-д зааснаар тасалдуулах хүчин зүйл нь:

- Прокурор болон хохирогчийн санаачилгаар хэргийг нээх, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх,

- Эрх бүхий байгууллагаас явуулсан мөрдөн шалгах, яллах бүхий л үйл ажиллагаа (протокол үйлдэх, гэрчийн мэдүүлэг авах, нэгжлэг хийх, шинжилгээ томилох, яллагдагчаар татах),
- Шүүхийн ямар ч шийдвэр (шүүхэд шилжүүлэх, эцсийн бус шийдвэр ч байсан хамаарах) зэрэг өргөн хүрээг хамарсан процессийн ажиллагааг багтаадаг.

Өөрөөр хэлбэл, Францын тогтолцоонд эрүүгийн хариуцлагыг сахиулах төрийн байгууллагын аливаа идэвхтэй оролцоо хугацааг тасалдуулах хүчин зүйлд багтдаг бол Монголын хувьд зөвхөн яллагдагчаар татах, шүүхэд шилжүүлэх гэсэн хоёр үндсэн үйлдлээр хязгаарлагдсан байдаг.

Энэ нь Монголын тогтолцоонд мөрдөн шалгах, баримт цуглуулах үе шатанд прокурор, мөрдөн байцаагчдын аливаа ажиллагаа хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулахгүй гэсэн ойлголтыг бий болгодог. Иймд цаг хугацаа алдалгүй яллагдагчаар татах ажиллагааг хийх шаардлага нэмэгддэг бөгөөд энэ нь мөрдөн шалгах ажиллагааны чанар, үргэлжлэх хугацаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Иймд Францын эрх зүйн системд нэвтрүүлсэн уян хатан, бодит нөхцөлд нийцсэн зохицуулалтын туршлагыг Монголын нөхцөлд судалж, тасалдуулах болон зогсоох үндэслэлүүдийг тодорхой болгох, илүү нарийвчлан хуульчилж өгөх хэрэгтэй бөгөөд. Энэ нь эрүүгийн процессийг үр ашигтай зохион байгуулах, хөөн хэлэлцэх хугацааны шударга хэрэглээ, хариуцлагын бодит хэрэгжилтийг хангах, улмаар нотлох баримт бүрдүүлэх нөхцөлийг сайжруулах алхам болох боломжтой.

#### Хүснэгт 2.7 Франц Монголын харьцуулалт

Үзүүлэлт	Францын эрх зүй	Монголын эрх зүй
1. Тасалдуулах (Interruption)	Хөөн хэлэлцэх хугацаа нь прокурор, мөрдөн шалгах байгууллагын аль ч идэвхтэй процессийн ажиллагаа(протокол үйлдэх, гэрчээс мэдүүлэг авах, нэгжлэг хийх, яллагдагчаар татах, шүүхэд шилжүүлэх гэх мэт) эхэлмэгц бүрэн тасалдаж, шинээр хугацаа тоологддог.	Зөвхөн яллагдагчаар татах болон шүүхэд шилжүүлэх гэсэн хоёрхон нөхцөл нь хугацааг тасалдуулна гэж Эрүүгийн хуулийн 1.10 зүйлд хуульчилсан. Бусад процессийн ажиллагаа (байцаалт, гэрчээс мэдүүлэг авах, нэгжлэг, дүгнэлт гаргуулах гэх мэт) тасалдуулах үндэслэлд тооцогддоггүй.
2. Тасалдуулахын ач холбогдол	Төрийн байгууллагын аливаа хэрэгжүүлж буй шалгалт, ажиллагаа хөөн	Идэвхтэй мөрдөн шалгалт явагдаж байсан ч хэрвээ яллагдагчаар татах ажиллагаа

	хэлэлцэх хугацааг шинээр эхлүүлдэг тул хугацаа дууссан шалтгаанаар ял завших боломжгүй болдог.	хийгдээгүй бол хугацаа дууссан гэж тооцож хэрэг хаах нөхцөл бүрддэг. Энэ нь олон хэргийн ял завших шалтгаан болсон.
3. Зогсоох (Suspension)	Хуульд нарийвчлан заасан нөхцөлүүдийн үед хугацаа түр зогсдог: – Халдашгүй байдал – Давагдашгүй хүчин зүйл – Урьдчилан шийдэх маргаан – Зуучлал, эвлэрэл Эдгээр нөхцөл арилсны дараа хугацаа хуучин цэгээсээ үргэлжилдэг.	Монголын Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацаа зогсоно гэх тодорхой, тусгай зохицуулалт бараг байдаггүй. Халдашгүй байдал, дипломат эрх, дайн, гамшиг зэрэг хуульд тусгагдаагүй учраас ийм нөхцөл үүссэн ч хугацаа явж л байдаг.
4. Зогсоох механизмыг хуульчилсан байдал	Францын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9-3 дугаар зүйлд тодорхой тохиолдол, нөхцөл, үр нөлөөг нарийвчлан заасан.	Монголын эрх зүйд зогсоох тухай ерөнхий, заалт ч үгүй шахам. Хууль сахиулахад уян хатан боломж олгодоггүй, хугацаа автоматаар үргэлжилсээр байдаг.
5. Практикт үзүүлэх үр нөлөө	Хөөн хэлэлцэх хугацааг шударга, уян хатан хэрэгжүүлэх боломж бүрддэг. Прокурор, мөрдөн байцаагч, шүүгч нар процессийн явцад хугацааг хамгаалах эрх зүйн хэрэгсэлтэй.	Эрүүгийн хэрэг цаг тухайд шалгагдаагүй бол хугацаа шууд дуусдаг. Прокурор, мөрдөн шалгах байгууллага хугацааг зогсоох, тасалдуулах эрх зүйн хэрэгсэлгүй тул ял завших эрсдэл өндөр.

## САНАЛ

Судалгааны үр дүн, онолын дүн шинжилгээ, хууль хэрэглээний практикийн нөхцөл байдлыг харгалзан дараах саналуудыг дэвшүүлж байна. Эдгээр нь Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоог илүү тодорхой, шударга, үр нөлөөтэй байлгах зорилготой болно:

Хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн шинжийг тодорхой болгох: Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд тусгасан хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн шинжтэй хэмээн хууль тогтоомжид тодорхой тусгаж, хууль буцаан үйлчлэхгүй байх зарчимд нийцүүлэн хэрэглээний нэг мөр байдлыг хангах шаардлагатай. Үүнийг Үндсэн хуулийн Цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтэд нийцүүлэн хуульчлах нь зүйтэй.

Хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг илүү тодорхой болгох: Яллагдагчаар татах хүртэл хугацааг хэтэрхий тодорхойгүй тооцож байгаа нь хэрэгсэхгүй болох нөхцөлийг үүсгэж байгааг харгалзан, хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхэлж тоолох, түдгэлзүүлэх, зогсоох, сэргээх нөхцөлүүдийг нарийвчлан хуульчлах шаардлагатай. Энэ нь мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хяналт, хүний эрхийн баталгааг харгалзсан уян хатан зохицуулалт байх ёстой.

Шүүхийн практикт нэгдмэл хэрэглээ бий болгох: Үндсэн хуулийн Цэц болон Улсын Дээд Шүүхийн хоорондын зөрүүтэй тайлбарыг нэг мөр болгохын тулд Улсын Их Хурал хууль тогтоох түвшинд Цэцийн дүгнэлтийг хэрэгжүүлж, хуулийн нэг мөр хэрэглээг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай. Энэ нь иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчимд нийцнэ.

Гадаадын туршлагаас суралцаж, механизмыг боловсронгуй болгох Францын зогсоох, түдгэлзүүлэх механизм, Германы ялын дээд хэмжээнд үндэслэн хугацаа тооцох тогтолцоо зэрэг туршлагыг судлан, Монголын эрх зүйн орчинд тохируулан шингээх нь зүйтэй. Тухайлбал, нотлох баримт бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоох зохицуулалт оруулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.

Хэрэг бүртгэл, мөрдөн шалгах байгууллагын ачааллыг зохистой түвшинд барих бодлого хэрэгжүүлэх Хөөн хэлэлцэх хугацааны богино байдал нь мөрдөн шалгах шатанд олон хэргийг хаах нөхцөл болдгийг харгалзан, мөрдөн байцаагчийн ачааллыг бууруулах, хэргийг шуурхай шийдвэрлэх институцийн чадавхыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хөөн хэлэлцэх хугацааны талаарх олон нийт, хууль сахиулагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх: Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны агуулга, хэрэглэх нөхцөл, үр дагавар зэргийг шүүх, прокурор, мөрдөн шалгах албан хаагч, хуульч мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, гарын авлага, тайлбар зэргээр дамжуулан ойлгомжтой хүргэх хэрэгтэй.

Иймд дээр дурдсан саналуудыг хэрэгжүүлснээр Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт илүү шударга, тодорхой, үр нөлөөтэй болж, хүний эрх, төрийн яллах үүргийн тэнцвэртэй хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэх боломжтой гэж үзэж байна.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хэрэгжиж буй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийн тулгамдсан асуудлуудыг нарийвчлан судалж, онолын болон практик ач холбогдлыг тодорхойлсны үндсэн дээр дараах нэгдсэн дүгнэлтэд хүрлээ.

Нэгдүгээрт, Монгол Улсын эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь түүхэн хөгжлийн явцад олон удаагийн өөрчлөлт шинэчлэлтээр дамжин боловсронгуй болж ирсэн хэдий ч, материаллаг болон процессын шинж чанарын талаар онолын түвшинд бүрэн тодорхойлогдоогүй байгаагаас эрх зүйн тодорхойгүй байдал, ойлгомжгүй байдал, зөрчилтэй тайлбарууд бий болсон байна. Энэ нь эрүүгийн эрх зүйн системийн тогтвортой байдлыг алдагдуулж, эрх зүйн практикт хүндрэлийг үүсгэж байна.

Хоёрдугаарт, эрүүгийн хуульд туссан хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт тодорхойгүй байгаагаас шалтгаалан прокурор, мөрдөн шалгах байгууллага болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгох тохиолдол эрс нэмэгдэж, улмаар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд ял завших нөхцөл бүрдэх, гэмт хэргийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах боломж хязгаарлагдах зэрэг сөрөг үр дагаврууд бий болжээ. Энэ нь эрүүгийн эрх зүйн үндсэн зорилго болох шударга ёсыг хангах, хүний эрхийг баталгаажуулах зарчимд шууд харшилж байна.

Гуравдугаарт, эрүүгийн процессын эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааг тоолох аргачлалын талаар нэгдсэн ойлголт, нэг мөр хэрэглээ бий болоогүйгээс шалтгаалан эрх зүйн хэрэглээний жишиг тогтоогдоогүй бөгөөд мөрдөн шалгах, шүүхийн практикт удаашрал, зөрчил маргааныг үүсгэж, процессын үр нөлөөг бууруулж байна.

Дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн Цэц болон Улсын Дээд шүүхийн хооронд хөөн хэлэлцэх хугацааны материаллаг болон процессын шинжийн талаар эсрэгцсэн байр суурь гарсан нь эрх зүйн маргааныг үүсгэж, практик хэрэглээний түвшинд хуульчдын болон эрх зүй хэрэглэгчдийн дунд ойлгомжгүй байдлыг бий болгож, эрх зүйн тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг үүсгэж байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг олон улсын эрх зүйн туршлага, харьцуулсан судалгаанд тулгуурлан материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж тодорхойлон, нэг мөр тусгайлан хуульчлан тогтоох шаардлагатай байна. Үүний зэрэгцээ эрүүгийн процессын эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, хөөн хэлэлцэх хугацааг тоолох нарийвчилсан журам, нөхцөлийг хуульд тодорхой зааж өгснөөр шүүхийн нэгдсэн

хэрэглээ, жишиг бий болгох боломж бүрдэх юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны шатанд хэргийг шуурхай, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ачааллыг оновчтой хэмжээнд байлгах зорилгоор процессын хугацааг бодитойгоор хязгаарлах, прокурорын хяналтын механизмыг илүү үр дүнтэй болгох хөгжингүй орнуудаас суралцаж илүү боловсруулан хуульчлах шаардлагатай гэж үзэж байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр эрүүгийн эрх зүйн тогтолцоонд шударга ёс, хүний эрхийн баталгаа хангагдаж, эрх зүйн тодорхой байдал бий болж, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хэрэглээний түвшин олон улсын жишигт хүрэх боломжтой болно.

## НОМ ЗҮЙ

### *Монгол хэлээрх:*

- 1.Амарсанаа, Ж. (2010). Хууль зүйн тайлбар толь. Улаанбаатар: Хуульчдын холбоо хэвлэлийн газар.
- 2.Батхүлэг, С. (2022). Эрүүгийн эрх зүй II боть: Онол ба практик (СЭЗИС-ийн багшийн удирдамж, редакц). Улаанбаатар: Санхүү, эдийн засгийн их сургууль.
- 3.Баянзүрх дүүргийн прокурорын газар. (2024). 2020–2024 оны мөрдөн шалгах ажиллагааны дүн шинжилгээний тайлан.
- 4.Баянзүрх дүүргийн Прокурорын газар. (2024). 2020–2024 оны мөрдөн шалгах ажиллагааны тайлан – Дүүргийн түвшний хэрэгсэхгүй болсон хэргүүдийн тоо, үндэслэл, дүн шинжилгээ.  
(Эшлэл: Бичгээр өгөгдсөн дүн мэдээ, дипломын хавсралтад ашигласан)
- 5.Ганбат, Ж. (2021). Хөөн хэлэлцэх хугацааны онол-практикийн зөрчил. Хуульч сэтгүүл, №2, х. 27–29.  
(Хөөн хэлэлцэх хугацааны материаллаг болон процессын шинж чанарын ялгаа, ҮХЦ–УДШ–УИХ-ын байр суурийн зөрчлийг шүүмжлэн судалсан бүтээл)
- 6.Ганбат, Ж. (2021). Хөөн хэлэлцэх хугацааны онол-практикийн зөрчил. Хуульч сэтгүүл, №2, х. 27–29.
- 7.Гомбосүрэн, П. (2019). Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тусгай анги: Ерөнхий ойлголт, тайлбар. Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн газар.
- 8.Гомдлын жишээ баримт – Иргэн Н.Ариунболд, Э.Түмэнбаяр, Б.Баяраа, Д.Оросоо, Х.Нямдорж нарын ҮХЦ-д гаргасан гомдлууд.
- 9.Зоригтбаатар, Н. (2018). Эрүүгийн эрх зүйн тусгай ангийн тайлбар. Улаанбаатар: Содпресс.
- 10.Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. (2024). Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьсан жилийн тайлан.

11. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. (2024). Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьсан жилийн эцсийн тайлан – Улсын хэмжээнд хөөн хэлэлцэх хугацаанд хэрэг хаагдсан тохиолдлын тоо, ангилал зэрэг статистикийн үндэслэлтэй.
12. Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
13. Монгол Улсын Их Хурал. (2015, 2017, 2020). Монгол Улсын Эрүүгийн хууль. Улаанбаатар: Хэвлэлийн газар.
14. Монгол Улсын Их Хурал. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Улаанбаатар: Хэвлэлийн газар.
15. Монгол Улсын Их Хурал. (2020). Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.01.10) – Хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох зохицуулалт оруулсан.
16. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц. (2020). Дүгнэлт №03 (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр) – Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуультай нийцэх эсэх маргааныг шийдвэрлэсэн дүгнэлт.
17. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц. (2020). Дүгнэлт №03 (2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр) – Хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох нь Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаарх маргааныг шийдвэрлэсэн.  
(Эшлэл: ҮХЦ-ийн албан ёсны цахим сайт болон дипломд ашиглагдсан эх сурвалж)
18. Нарангэрэл, С. (2008). Монголын эрх зүйн эх толь бичиг. Улаанбаатар: Бемби сан.  
(Хөөн хэлэлцэх хугацааны онолын тодорхойлолт, эрүүгийн хариуцлагын үндэслэл)
19. Нарангэрэл, С. (2008). Монголын эрх зүйн эх толь бичиг. Улаанбаатар: Бемби сан.
20. Нармандах, С. (2015). Эрүүгийн эрх зүйн судалгаа, бодлогын дүн шинжилгээ. Улаанбаатар: Хуульч хэвлэл.

- 21.Совд, Г. (2009). Эрүүгийн хуулийн тайлбар (2 дахь хэвлэл). Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэн.  
(Хөөн хэлэлцэх хугацааны хэрэглээний практик, хэрэгсэхгүй болгох үндэслэлийн тухай дүн шинжилгээ)
- 22.Содов, Д. (2007). Эрүүгийн эрх зүйн онолын үндэс. Улаанбаатар: Багшийн дээд сургууль.  
(Эрүүгийн эрх зүйн суурь зарчим, ял завшуулах боломжийг багасгах онолын үндэслэл)
- 23.Содов, Д. (2007). Эрүүгийн эрх зүйн онолын үндэс. Улаанбаатар: Багшийн дээд сургууль.
- 24.Улсын Дээд Шүүх. (2022). Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн албан ёсны тайлбар.
- 25.Улсын Дээд Шүүх. (2022). Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн албан ёсны тайлбар – Процессын шинжтэй хэм хэмжээ хэмээн тайлбарласан.
- 26.Хүний эрхийн олон улсын пакт (ICCPR). (1966). International Covenant on Civil and Political Rights – Статус болон шүүхийн өмнө эрх тэгш байдал, шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийн талаарх олон улсын баримт бичиг.
- 27.Чимэд, Ч. (2015). Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлууд. Улаанбаатар: Сэлэнгэпресс.  
(Материаллаг эрх зүйн хэм хэмжээний талаарх онолын суурь тодорхойлолт, хөөн хэлэлцэх хугацааг процессын хэм хэмжээнд авч үзэхийн хор уршгийг шүүмжилсэн)
- 28.Чимэд, Ч. (2015). Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлууд. Улаанбаатар: Сэлэнгэпресс хэвлэлийн газар.

***Гадаад хэлээрх:***

- 1.Bundesgerichtshof (BGH). (2022). Urteil vom 20. Januar 2022 – 1 StR 483/21.  
Entscheidungen zur Verjährungsunterbrechung nach § 78c Abs. 1 Nr. 1 StGB.
- 2.Code de procédure pénale français. (2024). Article 9-3 – Suspension et interruption de la prescription. Disponible sur: <https://www.legifrance.gouv.fr>

3. Code pénal français. (2024). Loi n° 92-1336 du 16 décembre 1992 portant réforme du Code pénal. Version consolidée. Disponible sur: <https://www.legifrance.gouv.fr>
4. Cornu, G. (2010). *Vocabulaire juridique* (10e éd.). Paris: Presses Universitaires de France.
5. Pradel, J. (2018). *Droit pénal général* (20e éd.). Paris: Cujas.
6. Pradel, J. (2018). *Droit pénal général* (20e éd.). Paris: Cujas. (Францын эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны ангилал, зогсоох, түдгэлзүүлэх механизмын онолын тайлбар)
7. Roxin, C. (2006). *Strafrecht: Allgemeiner Teil* (Band 1, 4. Auflage). München: C.H. Beck. (Германы эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэргийн шинж, ялын дээд хэмжээнд тулгуурладаг онолын үндэс)
8. Roxin, C. (2006). *Strafrecht: Allgemeiner Teil* (Band 1, 4. Auflage). München: C.H. Beck.
9. Strafgesetzbuch (StGB). (2024). §§ 78–78c – Verjährung (Statute of limitations). Bundesministerium der Justiz. Disponible sur: <https://www.gesetze-im-internet.de/stgb>
10. Tanaka, T. (2020). *Criminal Procedure in Japan: Basic Concepts and Legal Framework*. Tokyo: University of Tokyo Press. (Японы эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөөн хэлэлцэх хугацааны дүрэм, хүний эрхийн баталгаа)
11. UN Human Rights Committee. (2007). General Comment No. 32: Article 14 (Right to a fair trial). CCPR/C/GC/32. (Шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийн тухай олон улсын эрх зүйн тайлбар, хөөн хэлэлцэх хугацаа удаашрал үүсгэвэл зөрчил болох талаар)
12. Zappalà, S. (2009). *Human Rights in International Criminal Proceedings*. Oxford University Press. (Lex mitior зарчмын тайлбар, эрүүгийн эрх зүйн буцаан үйлчлэхгүй байх зарчмын онол-практикийн анализ)